***Эм зүйчийн мэргэжлээр эм барих зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил***

Сорил хариулах заавар:

**1.Нэг сонголттой тест** ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь A, B, C, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
**2.Олон сонголттой тест** ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
Бүх хариулт зөв бол (E.)
**3.Шалтгаан хамаарлын тест** (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
Зөв, Зөв, Зөв (A.)
Зөв, Зөв, Буруу (B.)
Зөв, Буруу, Буруу (C.)
Буруу, Зөв, Буруу (D.)
Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Маслоугийн хэрэгцээнд нь тулгуурлан хүнийг идэвхижүүлэх онолын үзэл баримтлалын “Пирамид” загварын суурь хэрэгцээ нв аль вэ?
A. Амжилтын хэрэгцээ
B. Өөрийгөө хамгаалах хэрэгцээ
C. Нийгмийн хангамжийн хэрэгцээ
D. Эрх мэдлийн хэрэгцээ
E. Физиологийн хэрэгцээ
/2./ Ажлын шинжилгээг хийснээр ямар мэдээлэл олж авдаг вэ?
A. Ажил-үр дүн
B. Ажил- үйл ажиллагаа
C. Үйл ажиллагаа-үр дүн
D. .Ажилчид- үр дүн, ажил- үр дүн
E. Ажилчид-ажил
/3./ Хэрэв гүйцэтгэл нь стандартаас дутуу байх үед менежер ямар үйл ажиллагаа явуулах вэ?
A. Шийтгэл оногдуулах
B. Засварлах
C. Арга хэмжээ авах
D. Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх
E. Стандартаа шинэчлэх
/4./ Удирдлагын шийдвэр гаргах явцад менежерт мэдээлэл хангалтгүй байх нь юу гэсэн үг вэ?
A. Аз туршилт хийх
B. Асуудлын шинж байдлын бүрдэлт муу
C. Тодорхойгүй байдал
D. Асуудлын мэдээллийн хомсдол
E. Удирдлагын шийдвэрийн онцлог
/5./ Манлайлагч бол удирдлагадаа байгаа хүмүүсийн хүсэл сонирхолоос шалтгаалж, тэдний зан байдлыг өөрчлөх хэрэгтэй гэсэн итгэл найдвар дээр үндэслэгдсэн онолын үзэл баримтлалд аль онол нь орох вэ?
A. Фидлерийн загвар
B. Манлайллын хэлбэрийн онол
C. Амьдрал давтамжийн онол
D. Зам-зорилгын онол
E. Хувь хүний үүднээс хандах хандлага
/6./ Байгууллагын ажилчид нь өөрсдийгөө илэрхийлэх, нийгмийн болон аюулгүй байдлын хэрэгцээгээ хангахын тулд бүлэг байгуулах шалтгаантд аль нь орох вэ?
A. Эдийн засгийн шалтгаан
B. Нийгэм, сэтгэл зүйн шалтгаан
C. Бодит шалтгаан
D. Нийгмийн шалтгаан
E. Сэтгэл зүйн шалтгаан

/7./ Үйл ажиллагаа нь байгууллагын зорилго ба стандарттай нийцэх магадлалыг тодорхойлдог аргыг юу гэх вэ?
A. Урьдчилсан хяналт
B. Явцын хяналт
C. Буцах холбооны хяналт
D. Хяналтын систем
E. Стратегийн хяналтын систем

/8./ Өрсөлдөөний шинжилгээг хийхэд ашигладаг аргуудад аль нь багтах вэ?
A. Зах зээлд шинээр орж ирэгчдийг судлах
B. Өрсөлдөгчийн үйл ажиллагааг судлах
C. Портерийн загвараар судлах
D. Орлуулах бүтээгдэхүүн, үйлчилгээг судлах
E. Портер-Лоулерийн загвараар судлах

/9./ Стратегийн менежментийн үйл ажилгаанд аль нь багтах вэ?
1. Дотоод орчны шинжилгээ
2. Гадаад орчны шинжилгээ
3. Стратегийн томъёололт
4. Стратегийн хэрэгжүүлэлт
5. Стратегийн хяналт

/10./ Шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлүүдэд багтах хувилбарыг сонгоно уу
1. Байгууллагын хүчин зүйлүүд
2. Хувь хүний эрхэмлэдэг зүйл ба байгууллагын соёл
3. Шийдвэр гаргах хурд
4. Бүтээлч хандлага ба шинийг гаргах
5. Менежерийн мэдээлэлд түшиглэх

/11./ Ямар ч байгууллагын оршин тогтнох үндэс нь юу вэ?
1. Зохион байгуулалт, эрх мэдэл
2. Дотоод орчин
3. Материаллаг үндэс
4. Гадаад орчин
5. Эдийн засаг

/12./ Хяналтын үйл явцад багтах хувилбарыг сонгоно уу?
1. Шаардлагатай мэдээллийг цуглуулах
2. Мэдээллэлд шинжилгээ хийх
3. Үйл ажиллагаа нь төлөвлөлттэй тохирч буйг харьцуулах
4. Хэлбэлзлийг тогтоох
5. Дүгнэлт хйих

/13./ Шийдвэр гаргалтын үе шатуудыг сонгоно уу?
1. Асуудлыг оношлох буюу харьцуулах
2. Шийдвэр гаргах хувилбаруудыг бий болгох
3. Хувилбарыг үнэлэх, сонгох
4. Хамгийн оновчтой хувилбарыг сонгох
5. Шийдвэрээ хэрэгжүүлэх ба үр дүнг тооцох

/14./ Бүлгийн шийдвэр гаргалт хэд хэдэн давуу талтай.
1. Хэд хэдэн хүмүүсээс бүрдэх учир мэдээлэл хангалттай цуглуулах боломжтой
2. Асуудал шийдвэрлэх өөр өөр аргыг бий болгодог.
3. Бүлгийн хэлцэл нь оюуны өрсөлдөөн дээр явагддаг тул зөв шийдвэр гарч, үр дүнд хүрдэг.
4. Олон хүн цугладаг тул шийдвэрт хурдан хүрэх боломжтой
5. Үргэлж зөв шийдвэр гардаг.

/15./ .Удирдагч нь шийдвэр гаргалтанд ганцаар ноёрхох, бусдын санаа бодлыг зөвшөөрөхгүй байх явдлаас зайлсхийх хэрэгтэй. Яагаад гэвэл бүлгийн гишүүдийн санаа бодлыг урамшуулах нь зөв шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой байдаг.

/16./ Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороо дараах үүрэг хүлээнэ:
1. Эмнэлгийн эмч, мэргэжилтэн, үйлчлүүлэгчдэд шинэ эм хэрэглэх, эмийн талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах, тэдний эмийн хэрэглээний талаархи мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эмийн жагсаалтыг гаргах, сонголтын талаар зөвлөх;

3. Байгууллагын онцлогт тохирсон эмийн лавлах тогтмол гаргах, эмчилгээний удирдамж (стандарт) боловсруулахад эмч, мэргэжилтэнд туслах;

4. Эмийн гаж нөлөөг бүртгэх, тандах, үнэлгээ өгөх, мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

5. Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг оновчтой болгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

/17./ Эмийн хэрэгцээг тодорхойлохдоо нийт эмүүдийг хэд хэдэн бүлэгт хувааж хэрэгцээг тооцож болно. Аль нь зөв вэ?

1. Тасалдалтай байгаа эмүүдийн
2. Өргөн хэрэгцээний эмүүдийн
3. Хэрэглээнд шинээр нэвтэрч байгаа эмүүдийн
4. Мансууруулах, өвөрмөц үйлдэлтэй, нормчлогдсон эмүүдийн
5. Ховор өвчинд хэрэглэгддэг эмүүдийн

/18./ Хаягдлыг ялгасны дараа савлах уут, хайрцгийг өнгөөр ялгаж төрөлжүүлнэ. Үүнд:

1. Ердийн хаягдалыг хар өнгийн уут, саванд хийнэ.
2. Эмнэлэг- үйлчилгээний хог хаягдлыг шар өнгийн уут, саванд хийж олон улсын биологийн болон халдвартай хог хаягдлыг таних тэмдгийг тавина.
3. Хими цацраг идэвхитэй, эсэд хортой нөлөө үзүүлдэг хаягдлыг хүрэн өнгийн уут,саванд хийж, тус тусын таних тэмдэг тавина.
4. Халдварын зэрэглэл өндөртэй хаягдлыг цагаан өнгийн уут, саванд хийж халдвартай гэж бичнэ.
5. Щприц зэргийг улаан уутанд хийнэ.

/19./ Аль ч зэрэглэлийн эмийн санд хориглох зүйлүүд :

1. Соёлын болоод гоо сайхны бараа худалдаалах
2. Эмийн хэлбэрүүдийг үйлдвэрлэх
3. Усан уусмал найруулан бэлтгэх
4. Галены бэлдмэл үйлдвэрлэх
5. Бөөн эмийг жижиглэн савлаж худалдаалах

/20./ Хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн үйл ажиллагааг дараах аргуудаар судална.

1. Ажлын цагийн зарцуулалтаар судлах
2. Ажиллагсадын өвчлөлийг эмнэлгийн хуудас ба эрүүл мэндийн үзлэгээр судлах
3. Тохиолдолыг ажиглан бүртгэх
4. Шинжилгээний аргууд
5. Ажлын цагийн бүртгэлээр судлах

/21./ Үндэсний зайлшгүй шаардлагатай эмэнд хийдэг шинжилгээний аргыг сонгоно уу?

1. ABG шинжилгээ
2. ABC шинжилгээ
3. VEH шинжилгээ
4. VEH шинжилгээ
5. VYN шинжилгээ

/22./ ДЭМБ-аас мөрддөг эм сонголтын шалгуурт доорхи хувилбаруудын аль нь багтах вэ?

1. Эмнэлгийн тусламжийн янз бүрийн түвшинд хэрэглэж болохоор байх
2. Элдэв гаж нөлөө багатай байх
3. Үнэ хямд байх
4. Өвчтөн уух боломжтой байх
5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн байх

/23./ Нөөцийн өрөөнд эм барааг төрөлжүүлэн байрлуулна. Учир нь эмийн физик, химийн шинж чанарт тохируулан найдвартай хадгалах нөхцөл хангасан төхөөрөмж бүхий агуулахтай байх ёстой

/24./ Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт шинээр нийтийн үйлчилгээтэй эмийн сан нээв. Эм бараа борлуулалтыг ашиглан нийт ажилчдийн тоог хэрхэн тооцох вэ? (Борлуулалтыг мян/ төг-өөр авна)

A. Нийт ажилчдын тоо = 2.5 + 0,005 ЭББ/бөөний үнээр/ + 0,02 ЭББ/жижиглэнгийн үнээр/
B. Нийт ажилчдын тоо = 2,4 + 0,005 ЭББ/бөөний үнээр/ + 0,03 ЭББ/жижиглэнгийн үнээр/
C. Нийт ажилчдын тоо = 2,4 + 0,005 ЭББ/бөөний үнээр/ + 0,02 ЭББ/жижиглэнгийн үнээр/
D. Нийт ажилчдын тоо = 2,4 + 0,006 ЭББ/бөөний үнээр/ + 0,02 ЭББ/жижиглэнгийн үнээр
E. Нийт ажилчдын тоо = 2.4 + 0,005 ЭББ/бөөний үнээр/ + 0.2 ЭББ/жижиглэнгийн үнээр/

/25./ “X” эмийн сан жорын стационарын жорын төлөвлөлтийг хийхэд стационарын жорыг тооцох коэффициентыг тооцох шаардлага гаржээ. Дараах хувилбаруудын аль зөв бэ?

A. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын үзлэгийн тоо / жилийн ор хоног ашиглалт
B. Стационарын жорыг тооцох коэффициент = жилийн ор хоног ашиглалт/ стационарын жорын тоо

C. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын жорын тоо / жилийн ор хоногийн тоо
D. Стационарын жорыг тооцох коэффициент = стационарын жорын тоо / жилийн ор хоног ашиглалт
E. Стационарын жорыг тооцох коэффициент = жилийн ор хоногийн тоо/ стационарын жорын тоо

/26./ Х" эмийн сангийн эд хариуцагч А гадаад руу томилтоор яваад ирээгүй байв. Энэ үед тухайн эмийн санд "гэнэтийн ослын" тооллого хийх шаардлага гарав. Ямар шийдвэр гаргах вэ?
A. Ар гэрээс нь хүмүүсийг тооллогод оролцуулна
B. Хууль хяналтын байгууллагын ажилтан ба хөндлөнгийн оролцоотой хийнэ.
C. Тооллогыг комисс дангаараа хийнэ.
D. Эмийн сангийн эрхлэгч тооллогод оролцоно
E. Жор баригчийг иртэл нь тооллогыг хүлээнэ

/27./ Эмийн сангийн эргэлтийн хөрөнгийн нөөцийн эзлэх хувь нь ямар байвал зохимжтой вэ?
A. Дөрөвний гурав нь байвал
B. Дөрөвний хоёр нь байвал
C. Гуравны хоёр нь байвал
D. Аравны найм нь байвал
E. Хоёрны нэг нь байвал

/28./ Эмийн эргэлт удааширсан ч хэмжээ нь их байвал эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөн яах вэ?
A. Түргэснэ.
B. Орлого ихсэнэ.
C. Нэмэгдэнэ.
D. Зогсонги байдалтай болно.
E. Орлого буурна.

/29./ Тооллогоор эд хариуцагчийн эм бараанаас хагарч хэмхэрсэн, ширгэсэн, чанар байдал нь муудсан, хугацаа дууссан эм бараа гарвал ямар шийдвэр гаргах вэ?
A. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасна.
B. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасаж, тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ.
C. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнд оруулан тусгай бүлгээр бүртгэл үйлдэнэ
D. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнгээс хасаж, оруулан тусгай бүлгээр бүртгэл үйлдэн акталпа.
E. Тоологдсон зүйлийн ерөнхий дүнд оруулан акталпа

/30./ . "Х" эмийн сан стационарын жорын төлөвлөлтийг хийхэд жилийн ор хоногийг тооцох шаардлага гарчээ. Дараах хувилбаруудын аль зөв бэ?
A. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х ор хоног
B. Жилийн ор хоног = Төлөвлөсөн ор хоног х эмнэлгийн орны тоо
C. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х жилд ашиглах ор өдөр
D. Жилийн ор хоног = жилийн өдөр х эмнэлгийн орны тоо
E. Жилийн ор хоног = эмнэлгийн орны тоо х ор хоногийн коэффициент

/31./ Зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэснээр зардлын хэтрэлтэд хяналт тавих, орлого зардлыг харьцуулах, ашгийг хэмжих, мөн цаашдын төлөвлөгөө, төсөл зохиох судалгаа-шинжилгээ хийх, удирдлагын оновчтой шийдвэр гаргах зэрэгт онцгой ач холбогдолтой. Учир нь харин зардал бол борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний өртөг болно.

/32./ Эмийн сангийн хүлээн авах жор нь тоогоор болон мөнгөн хэлбэрээр төлөвлөгдөнө. Яагаад гэвэл жор нь эмийн сангийн орон тоо, туслах материалын зардал, ажлын ачаалал, зэрэглэл зэрэг эмийн сангийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг төлөвлөхөд хэрэглэгдэнэ.

/33./ Тооллогоор бүх хөрөнгө бараа материал нэг бүрчлэн тоологдож, хэмжигдэж, нүд үзэн тоолох хэрэгтэй. Яагаад гэвэл бөөнөөр савлагдсан баглаа боодолтой эм бараа задлагдсан байж болно

/34./ Чөлөөт зах зээл дээр борлуулалт бууралтын хэмжээг юу тодорхойлдог вэ?
A. Засгийн газар
B. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний нийлбэр
C. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний ялгавар
D. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний аль их нь
E. Эрэлт нийлүүлэлтийн хэмжээний аль бага нь

/35./ Эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох үг
A. Нөөц
B. Хэрэгцээ
C. Ховор хомс нөөц
D. Капитал

E. Байгалийн нөөц

/36./ Хүмүүсийн хэрэгцээг хангахуйц олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хийхэд шаардлагатай төрөл бүрийн хүчин зүйлсийг хооронд нэгтгэх үйл явцыг

A. хөдөлмөр
B. капитал
C. бүтээгдэхүүн
D. үйлдвэрлэл
E. үйлчилгээ гэнэ.

/37./ Сануулах чиглэлийн зарлал чимэглэлийг барааны амьдралын мөчлөгийн аль шатанд хийх нь зүйтэй вэ?

A. зах зээлд гарах
B. зах зээлд боловсрох
C. зах зээлд өсөх
D. зах зээлд унах
E. зах зээлд өрсөлдөх

/38./ Хүмүүсийн ямар нэгэн зүйл төлбөр хийх хүсэл ба чадварыг илэрхийлдэг нэр томъёо аль нь вэ?

A. Хэрэгцээ
B. Эрэлт
C. Шаардлага
D. Хүсэл
E. Сонирхол

/39./ Байгууллага, хүний эрэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бизнесийн хэвшил нийлүүлж, хариуд нь төлбөр авах үйл ажиллагааг маркетингийн ойлголтоор

A. хүчин зүйлсийн зах зээл
B. үйлвэрлэлийн зах зээл
C. бүтээгдэхүүний зах зээл
D. улсын байгууллагын зах зээл
E. хэрэглэгчдийн зах зээл

/40./ Үнийн доод түвшинг тогтоосноор:

A. Хомсдлыг бий болгоно
B. Эрэлтийг нэмэгдүүлнэ
C. Нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ
D. Эрэлт нийлүүлэлт хэвээр байна
E. Борлуулалтыг нэмэгдүүлнэ

/41./ Орлого өсөхөд дагалдах барааны эрэлт:

A. өснө
B. буурна
C. хэвээрээ
D. тодорхойлох боломжгүй
E. Өргөн хэрэглээний бараанд өснө

/42./ Бараа, үйлчилгээний нийлүүлэлт, эрэлт 2 хоорондоо харилцан тэнцэж байгаа байдлыг маркетингийн ухааны үүднээс юу гэж ойлгох вэ?

A. Эрэлтийн хангалт
B. Зах зээлийн тогтворжилт
C. Зах зээлийн тэнцвэр
D. Хэрэгцээний хангалт
E. Маркетингийн тооцоо

/43./ Маркетингийн төлөвлөлтийн суурь нь:

A. үйл ажиллагааны төлөвлөлт
B. бүтцийн төлөвлөлт
C. бодлогын төлөвлөлт
D. ашгийн төлөвлөлт
E. хүн хүчний төлөвлөлт юм.

/44./ Барааны үнэ нь эрэлттэй шууд хамааралтай байна учир нь үнэ өндөр бол эрэлт бага, үнэ бага бол эрэлт өндөр байна.

/45./ Тээвэрлэлт хадгалалтын онцгой горим шаардагдах вакцин, биобэлдмэл, оношлуур байдаг бөгөөд тэдгээрээс бусад барааг гаалийн агуулахаас татан авах үүргийг Эмимпэкс концерн хариуцах ба харин вакцин, биобэлдмэл, оношлуурын татан авалт, хадгалалт, тээвэрлэлтийг ХӨСҮТ гүйцэтгэнэ.

/46./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг эмчилгээний зорилгоор ашиглэх журам, нөхцлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх худалдах журмыг тогтоохдоо Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн заалтыг баримтална.

/47./ Даатгуулагчид олгох эм нь тухайн эмийн санд ерөнхий нэршлээр байхгүй үед худалдааны нэрээр орлуулан олгож болно. Энэ тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан үнийг даатгалын сангаас нөхөн төлөхгүй.

/48./ Нэгж бүтээгдэхүүний үнийг багасгахад нийт орлого буурна, яагаад гэвэл үнийг ихэсгэхэд нийт орлого буурч эрэлтийн мэдрэмж муу байна гэж үзнэ.

/49./ Хөвөн ба самбайн оронд хэрэглэдэг шилэн шүүлтүүрийн хэмжээг заана уу.
A. нүхний голч нь 90-120 мкм
B. нүхний голч нь 150-200 мкм
C. нүхний голч нь 40-150 мкм
D. нүхний голч нь 5-15 мкм
E. нүхний голч нь 15-40 мкм

/50./ №1 уур нүдүүрийн диаметр ( мм) -ийг заана уу?
A. 40 мм
B. 50 мм
C. 55 мм
D. 60 мм
E. 65 мм

/51./ Хэрэв жоронд тосон түрхэцийн суурийг заагаагүй ба техникийн баримт бичигт тосон түрхэцийн найрлага нь байхгүй байх тохиолдолд суурийг сонгож авахдаа юуг тооцох ёстой вэ?
1. Тосон түрхэцийн хэрэглэх зориулалтаар
2. Дисперсийн системийн төрөл
3. Эмийн бодисуудын физик химийн шинж чанар
4. Эмийн бодисын хэмжээ
5. Эмийн бодисын усанд уусах чанар

/52./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэхэд ямар шинж чанарыг тооцох ёстой вэ?
1. Түүхий эдийн эсийн бүтэц
2. Үйлчлэгч бодисын физик химийн шинж чанар
3. Дагалдагч болон балласт бодисын физик химийн шинж чанар
4. Шүүх арга
5. Экстрагентын эзэлхүүн

/53./ Фармакопейн заалтын дагуу лааны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?
1. Уусах хугацаа
2. Нэгэн төрөл
3. Задралт
4. Деформацид бүрэн орох хугацаа
5. Лааны жингийн хэлбэлзэл

/54./ Үрэлд ямар зорилгоор туслах бодисуудыг нэмдэг вэ?
1. үрэл эмэнд жин багтаамж олгох зорилгоор
2. үрэлд уян хатан байдал олгох зорилгоор
3. үрэлд хэлбэр дүрс олгох зорилгоор
4. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг ихэсгэх зорилгоор
5. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг хурдасгах зорилгоор

/55./ Цийдмэг эмийн хэлбэрийн давуу талууд:
1. Нэгэн төрлийн байдал
2. Гидрофиль ба липофиль шинж чанартай эмийн бодисуудыг цийдмэгийн найрлаганд оруулах боломжтой
3. Коалесценцийн процесст орох чадвар
4. Дотуур хэрэглэхэд зориулсан цийдмэгээс тос нь хурдан шимэгддэг
5. Термодинамикийн тогтвортой чанар

/56./ Зуурамтгай шинж чанартай уусгагч бүхий уусмалыг бэлтгэх ямар онцлог байдаг вэ?
1. Жингийн аргаар бэлтгэх
2. Ариутгасан хуурай олгох шилэнд халаах замаар уусгана.
3. Шаардлагатай бол хоёр давхар самбайгаар шүүнэ.
4. Жин-эзэлхүүний аргаар бэлтгэх

5. Халаах шаардлага гардаг учир хуурай шилэнд уусгана.

/57./ Лааны суурьнд тосон түрхэцийн сууриас ялгагдах ямар өвөрмөц шаардлагууд тавигддаг вэ?

1. Биеийн температурт уусдаг.
2. Биеийн температурт хайлдаг.
3. Тасалгааны температурт хатуу
4. Эмийн бодисыг хурдан чөлөөлдөг
5. Зөөлөн консестенцтэй байх

/58./ Ургамлын түүхий эдээс үйлчлэгч бодисыг бүрэн гүйцэд хандлахад юу нөлөөлдөг вэ?

1. Түүхий эд экстрагентын харьцаа
2. Диффузын процессын хурд
3. Хандлах дэглэм
4. Усан ялгамлын эзэлхүүн
5. Экстракт-концентратын эзэлхүүн

/59./ Хөвмөлийн дисперсийн фаз нь шингэн дотор үргэлж хөвж байж чаддаггүй. Учир нь таталцах хүчний нөлөөгөөр сидментацад ордог.

/60./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэх нь экстракт концентратаас бэлтгэснээс илүү сайн чанартай байдаг. Яагаад гэвэл үйлчлэгч бодисnúmber гүйцэд ялгардаг.

/61./ Жинтэй ажиллахдаа туухай ба жигнэх зүйлийг тавгийн голд тавина. Яагаад гэвэл жингийн зүүн тавган дээр туухайг, баруун тавган дээр эмийн бодисыг хийж жигнэнэ.

/62./ Зээрэнцэгт жигдрүүлэгч цагт хэдэн кг тосон түрхэц жигдрүүлдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 100-150кг/цаг
B. 80-120кг/цаг
C. 50-60кг/цаг
D. 60-90кг/цаг
E. 60-80кг/цаг

/63./ Дараах тодорхойлолтын аль нь хамгийн зөв бэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Хоорондоо үл холилдох 2 шингэн фазаас тогтсон дисперсийн системийг хөвмөл гэнэ.
B. Шингэн орчин дотор хатуу жижиг хэсгүүд болох дисперсын фазаас тогтсон бичил нэгэн төрлийн бус дисперсын системийг хөвмөл гэнэ
C. Шингэн дотор хийн бөмбөлөг жигд тархсан дисперсын системыг хөвмөл гэнэ.
D. Дотроо хатуу жижиг хэсгүүд агуулсан хийн холимогийг хөвмөл гэнэ.
E. Шингэн дотор тархсан хий ба хатуу фазуудын холимогийг хөвмөл гэнэ.

/64./ Дамжин бохирдох гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Нэг бүтээгдэхүүний эхлэл материал, дамжлагын бүтээгдэхүүн эсвэл бэлэн бүтээгдэхүүн нь өөр бүтээгдэхүүний эхлэл материал болон үйлдвэрлэлийн явцын материалаар бохирдохыг хэлдэг
B. Үйлдвэрлэлийн явцад завсрын ба эцсийн бүтээгдэхүүн нь өөр бусад эхний материал ба эцсийн бүтээгдэхүүнээр бохирдохыг хэлнэ
C. Эцсийн савлалт, хаяглалтыг оруулан үйлдвэрлэлийн бүх шатны бохирдолтыг хэлнэ.
D. Эмийн бүтээгдэхүүний чанарын өөрчлөлтийн шалтгаан нь болдог процесс юм
E. эхний материал, эцсийн савлалт, хаяглалт зэрэг нь үйлдвэрлэлийн бүх бүтээгдэхүүнийг бохирдуулахыг хэлнэ

/65./ Зарцуулалтын коэффициент гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Материалын алдагдлыг эхлэл материалтай харьцуулсан харьцааг хэлнэ.
B. Эхлэл материалын нийт хэмжээг бэлэн гарсан бүтээгдэхүүний хэмжээнд харьцуулсан харьцааг хэлнэ
C. Бэлэн бүтээгдэхүүнийг эхлэл материалтай харьцуулсан харьцааг хэлнэ
D. Бэлэн бүтээгдэхүүнийг эхлэл материалтай харьцуулсан харьцааг процентаар илэрхийлсэн илэрхийллийг хэлнэ.
E. Эхлэл материал, эцсийн бүтээгдэхүүний нийлбэр юм.

/66./ Тарилгын зориулалттай нэрмэл усны чанарыг сайжруулах, пироген бодисгүй болгохын тулд технологийн ямар шийдлийг сонгох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Усыг нэрэхдээ 1100-аас дээш температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар явуулна
B. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулахгүйгээр тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна.

C. Усыг нэрэхдээ менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар задгай буцалгаж нэрнэ.

D. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар, гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна

E. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тогтмол бус хурдтайгаар нэрэлтийг явуулна

/67./ Ариун бүтээгдэхүүн үйлдвэрлэх агаарын цэвэршилтийн В,С, Д зэрэглэлд хүрэхийн тулд агаарын солилцооны хэмнэл нь хэд байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 1 цагт 10-15
B. 1 цагт 20-с дээш
C. 1 цагт 15-с дээш
D. 1 цагт 10 дээш
E. 1 цагт 5-аас дээш

/68./ Хатуу биеийг жижиглэх процессын үр дүн нь юугаар илэрхийлэгдэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Жижиглэсэн материалын жижиглэлтийн ширхэгээр
B. Жижиглэсний дараах дундаж хэмжээгээр
C. Материалын жижиглэлтийн зэргээр
D. Жижиглэхээс өмнөх дундаж хэмжээгээр
E. Жижиглэлтийн үеийн дундаж хэмжээгээр

/69./ Бөмбөлөгт тээрмийн хурд маш их байвал төвөөс зугтах хүч бий болно. Ийм учраас жижиглэх үйл ажиллагаа маш сайн явагдана.

/70./ Шахмал хийх мөхлөгийг шахах үед таталцлын хүч бий болж хоорондоо хэлхэгдэн холбогдож гадаргууд нь нимгэн усан бүрхүүл үүсдэг. Учир нь энэ үед зөвхөн механик хүч үйлчилж байна гэж үздэг.

/71./ Зарим тарилгын уусмалыг ариутгах үед температурын нөлөөгөөр хими-физикийн өөрчлөлтөнд ордог. Ийм учраас түүнийг тогтворжуулах зорилгоор антиоксидант бодис нэмдэг.

/72./ Сахарын сироп нь осмос даралтаар өндөр байдаг тул микро организмын усыг хатааж, амьдрах орчинг үгүй хийдэг. Ийм учраас 60%-иас бага концентрацтай сиропыг эм зүйн практикт байнга хэрэглэдэг.

/73./ Хатуу желатинан капсулыг гарган авахдаа дуслын аргыг хэрэглэдэг. Учир нь тогтмол температуртай желатины уусмалд тэнхлэгээрээ эргэлдэх олон тооны металл хэвийг дүрээд авахдаа капсул хэлбэр үүсгэхэд үндэслэгддэг.

/74./ Бүрхүүл үүсгэгч нь тодорхой хэмжээний бат бөх, уян хатан шинж чанартай байх ёстой. Учир нь бүрхүүлд савлагдсан эмийн чанар байдал, эмчилгээний үр дүн нь бүрхүүлийн шинж чанараас шууд хамаарна.

/75./ Мөхлөг нь олон төрлийн фракцын бүрэлдэхүүнтэй байж болохгүй. Учир нь тэдгээр нь үелэн шахмалын дундаж жинд муугаар нөлөөлдөг.

/76./ Эмийн бодисыг бие махбодид тодорхой хугацаагаар тогтмол концентрацтай байлгахын тулд матрикс шахмалыг хийдэг. Ийм шахмалыг гарган авахын тулд сараалж үүсгэгч бодисыг ашиглах ба тэдгээрийн дотор биологийн идэвхт бодисыг байрлуулж өгдөг.

/77./ Цахилгаан гүйдлийн нөлөөгөөр дотоодын диффузын коэффициент ихэснэ. Учир нь биологийн идэвхт бодисын молекулын ионы хөдөлгөөн хурдасна.

/78./ Ямар ч түүхий эдийг хандлахын өмнө заавал дэвтээх шаардлагатай. Учир нь дэвтээхэд түүхий эд хөөж, хандлагч шингэн орох боломж сайжирна.

/79./ Этилийн спиртийн ээзлхүүний процентыг 200С-д хэмжинэ. Учир нь спиртийн ээзлхүүн температураас хамааран өөрчлөгддөг.

/80./ Түүхий эдийг хэт жижиглэх нь хандлалтанд сайнаар нөлөөлнө. Учир нь хэт жижиглэхэд хандлагч шингэний түүхий эдэд нэвчин орох чадвар нэмэгдэнэ.

/81./ Тодорхойлж буй бодисын –метокси бүлгийг бромын усаар исэлдүүлж аммиак нэмэхэд ногоон өнгөтэй о-хиноид бүтэц бүхий нэгдэл үүсэв. Энэ сорилын нэрийг сонгоно уу

A. Мурексид
B. Нингидрин
C. Таллейохин
D. Витали-Морены
E. Марки

/82./ Барбитурын хүчлийн уламжлалын бүтцийн үндэс нь ямар гетероцагираг вэ?

A. Барбитурын хүчлийн давс
B. Урацилын уламжлал
C. Пиримидин
D. Ангит цагирагт
E. 6 гишүүнт ангит цагирагт

/83./ Дор өгөгдсөн химийн нэр ямар антибиотикийнх болохыг заах. 4-диметиламино-1, 4, 4а, 5, 5а, 6, 11, 12а-октагидро- 3, 6, 10, 12, 12а пентаокси-6-метил-1, 11-дикетонафтацен-2 карбоксиамидын гидрохлорид

A. хлорамфеникол
B. тетрациклины гидрохлорид
C. окситетрациклины гидрохлорид
D. хлортетрациклин
E. хлормицетин

/84./ Дараах бодисуудын аль нь гликозид бүтэцтэй вэ?

A. Токоферол
B. Хлорамфеникол
C. Неодикумарин
D. строфантидин
E. Стрептомицины сульфат

/85./ Натрийн бромид 2гр, Новокайны гидрохлорид 1 гр бүхий 100 мл уусмалаас 1 мл-г авч 500мл-н хэмжээт колбонд хийж хэмжээс хүртэл нэрмэл усаар шингэлэв. Түүнээс 10 мл-г авч 25мл хүртэл нэрмэл усаар сулруулаад 288 нм-т спектрофотометрдэхэд D=0.650 байв. / E=639.9 / Новокайны гидрохлоридын хэмжээг гр-р ол?

A. 2.26
B. 1.26
C. 1.11
D. 1.23
E. 1.18

/86./ Карбоны хүчлийн эмийн бэлдмэлийн уусмалыг $H_2SO_4$ –ээр хүчиллэгжүүлж $KMnO_4$ нэмж халаахад ацетальдегидийн үнэр үнэртэв. Ямар анион бэ?

A. ацетат
B. цитрат
C. карбонат
D. лактат
E. глюконат

/87./ Барбитуратуудын натрийн давсуудын усанд уусах шинж чанар нь буурдаг нь юутай холбоотой вэ?

A. Исэлдэхтэй
B. Ангижрахтай
C. Полимержих
D. Нэгдэх урвалтай
E. Гидролизтай

/88./ Эмийн бэлдмэлийг усанд уусган, 1 мл мөнгөний нитратын аммиакийн уусмал нэмэхэд шаравтар өнгийн тунадас үүсч, халаахад бараан өнгөнд шилжин, хуруун шилний хананд" мөнгөн толь" үүсэв. Энэ ямар бэлдмэл байсан бэ?

A. Амидопирин
B. Антипирин
C. Изониазид
D. кордиамин
E. Никотинамид

/89./ Шүүлтийн цаасан дээр $FeCl_3$ дусааж, дээр нь эмийн хэлбэрээс 1 дусаахад хөх ягаан хүрээтэй боровтор шар толбо үүсэв. Эмийн хэлбэрт ямар ион агуулагдаж байна вэ?

A. ацетат
B. ацетат, бензоат
C. салицилат, бензоат
D. салицилат, ацетат
E. бензоат

/90./ Шинжилгээнд тосонд уусдаг. цайвар шар өнгийн, зуурамтгай, тосорхог шингэн (витаминий төрлийн) иржээ. Гэрэлд исэлдэж өнгө нь харладаг. Гэрлийн хугарлын илтгэгч нь 1,4960-1,4985. Энэ ямар витамин бэ?

A. ретинолын ацетат
B. эргокальциферол
C. токоферолын ацетат
D. холекальциферол
E. викасол

/91./ Эуфиллины усанд уусах чанар нь дараах ямар нөхцлөөс өөрчлөгддөг вэ?

A. Агаарын нүүрсхүчлээс
B. Гэрлээс
C. Агаарын хүчилтөрөгчөөс
D. Агаарын азотоос
E. Агаарын хүхрээс

/92./ Барбитуратуудыг хоорондоос нь ялган таних урвалжуудыг заана уу?

A. Кобальтийн нитрат
B. Мөнгөний нитрат
C. Зэсийн сульфат
D. $FeCl_3$
E. Давсны хүчил

/93./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтворжуулахын тулд натрийн метабисульфит эсвэл натрийн сульфит нэмж өгдөг. Учир нь аскорбины хүчил нь агаар, металл, хүчил, шүлтийн нөлөөгөөр амархан исэлддэг.

/94./ Бензойны хүчлийг эмнэлгийн практикт натрийн давс байдлаар хэрэглэдэг. Учир нь натрийн давс байдлаар хэрэглэхэд бензойны хүчлийн цочроох үйлдэл багасдаг.

/95./ Хортой, хүчтэй үйлчлэгч бодисуудыг усныууртай нэрэхэд эхлээд биоматериалыг хүчиллэгжүүлдэг. Ямар хүчлийг хэрэглэдэг вэ?

1. Чулуун дарсны хүчил
2. Хүхрийн хүчил
3. Хурган чихний хүчил
4. Цууны хүчил
5. Давсны хүчил

/96./ Гемодиализын аргыг ямар тохиолдолд хэрэглэхэд тохиромжтой вэ?

1. Хорт бодисууд цусны уурагтай бат бөх холбоо үүсгэдэг үед
2. Био шингэнд түргэн уусдаг бодисын хордлогын үед
3. Өөх тосны төрлийн бодистой бат бөх холбоо үүсгэсэн үед
4. Молекул жин багатай бодисын хордлогын үед
5. Хордлогын хожуу үед ч хэрэглэхэд тохиромжтой

/97./ Хүнд металлын давсын хордлогын үед хэрэглэх антидотыг заана уу?

1. Витамин B6 5% уусмал
2. Натрийн тиосульфатын 30% уусмал
3. Протамины сульфатын 1% уусмал
4. Унитол 5% уусмал
5. Танины уусмал

/98./ Метилийн спиртийн хоруу чанарыг заана уу?

1. Мэдрэлийн системийг гэмтээнэ.
2. Нүдний эвэрлэг бүрхүүл ба харааны мэдрэлийг гэмтээнэ.
3. Зүрх судасны системийг гэмтээнэ.
4. Нүд сохлоно
5. Этанолын исэлдэлтийг 50% хүртэл бууруулна.

/99./ Манганийн нэгдлийн бие махбодид үзүүлэх хорт нөлөөллийг заана уу?

1. ТМС-д нөлөөлнө.
2. Бөөр гэмтээнэ.
3. Уушиг гэмтээнэ.
4. Элэг гэмтээнэ.
5. Ходоод гэдэсний ханыг түлнэ.

/100./ Никотины хүчлийн хордлогын үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

1. ТМС дарангуйлагдана
2. Толгой эргэх
3. Бөөлжих, гүйлгэх
4. Амьсгалын төв дарангуйлагдана
5. Хүүхэн хараа нарийсах

/101./ Шинжилж буй уусмал дээр фенолфталеины спиртийн уусмал нэмэхэд ягаан өнгөтэй болох ба үүн дээр барийн хлорид нэмэхэд шинжилж буй материалд идэмхий шүлт байвал фенолфталеины ягаан өнгө

1. Арилна
2. Хөх өнгөнд шилжинэ
3. Улаан өнгөнд шилжинэ
4. Хэвээр хадгалагдана
5. Улбар шар өнгөнд шилжинэ

/102./ 1 мл шинжилж буй уусмал дээр 1 мл 1% шинэхэн бэлтгэсэн резорцины шүлтлэг уусмал нэмж халаахад ягаан өнгө үүссэн бол уг дээжинд ямар хорт бодис агуулагдаж байна вэ?

1. Хлороформ
2. Хлоралгидрат
3. 4 хлорт нүүрстөрөгч
4. Формальдегид
5. Синилийн хүчил

/103./ Сапонин нь дараахь түүхий эдийн үндсэн үйлчлэгч бодис

A. Строфантын үр жимс
B. Чихэр өвсний үндэс
C. Алтан хундагын өвс
D. Бамбайн үндэс ба үндэслэг иш
E. Алтан гагнуурын үндэс ба үндэслэг иш

/104./ Ямар биологийн идэвхит бодис агуулсан түүхий эдэд биологийн стандартчилал явуулдаг вэ?

A. Алкалоид
B. Эфирийн тос
C. Зүрхний гликозид
D. Антроцений уламжлалууд
E. Экдизонууд

/105./ Ферментүүдийн ангилалыг зөв нэрлэнэ үү.

1. Ялгаруулагч ферментүүд
2. Оксиредуктазууд буюу исэлдэн ангижрах урвалыг хурдасгах ферментүүд
3.Эд эсийн нөхөн төлжилтийг дэмжих үйлдэлтэй ферментүүд
4. Гидролазууд буюу задралд оруулагч ферментүүд
5. Коферментүүд

/106./ Шувуун тарнаас ямар биологийн идэвхт бодисийг цэвэршүүлэн ялган авдаг вэ?

1. Мочевин
2. Кверцетин
3. Рутин
4. Авикулярин
5. Апигенин

/107./ Витамин агуулсан түүхий эдийг усанд ба тосонд уусдаг гэж 2 ангилна. Учир нь химийн бүтцээр нь ангилдаггүй.

/108./ Эмийн ургамлын түүхий эдийг 10-12%-ийн чийглэгтэй болтол нь хатааж хэрэглэдэг. Яагаад гэвэл эд эсэд орших биологийн идэвхт бодис нь чанараа алдаагүй байдаг.

/109./ Ургамлын түүхий эдэд флавоноид илрүүлэх энгийн арга нь Цианидиний сорил юм. Тийм учраас хроматографын аргуудаас өмнө энэ таних урвалыг ихэвчлэн явуулдаг.

/110./ Уламжлалт монгол анагаах ухааны онол дахь өвчнийг эмчлэх ерөндөгийг зөв сонгоно уу.

1. Эм
2. Засал
3. Идээ
4. Ундаа
5. Явдал мөр

/111./ Гар, хөл, үе мөч хөших, хөл гарыг жийж хумихад өвдөх, хүчлэхэд хатууран хавдах зэргийг дарж чадах эмийг ямар эрдэмтэй эм гэх вэ?
1. Зөөлөн эрдэмтэй эм
2. Хүндийн эрдэмтэй эм
3. Бүлээний эрдэмтэй эм
4. Тослог эрдэмтэй эм
5. Батлаг эрдэмтэй эм

/112./ Гишүүнийг номхотголгүйгээр хэрэглэвэл ямар үйлдэл үзүүлэх вэ.
A. Хурж бөөгнөрснийг тараана
B. Урвуу арилгагч хийн гүйдлийг сайжруулна.
C. Хүний цусны тунгалагийн эсрэг цогцын урвалыг таслана
D. Бактерийг устгана.
E. Ходоодыг хялбар гэмтээнэ.

/113./ Жигнэж номхотгох аргын зорилго
1. Эмт бодисын чанар чадлыг өөрчлөх
2. Хэрэглэх хэмжээг өргөтгөхийн төлөө
3. Эмт бодисын ашигт бүрэлдэхүүнийг хурааж хадгалахд ашигтай болгох
4. Эмт бодисын муу үйлдлийг багасгах
5. Хэрчиж зүсэхэд дөхөм болгохын төлөө

/114./ Мана-4 тангийн чадал
1. Хий цусны хатгалгааг дарна
2. Хий цусны хатгалгааг дарна
3. Хижгийн халууныг боловсруулна
4. Халууныг боловсруулна.
5. Цайвар бор бадганыг дарна.

/115./ Нурамлах аргын зорилго. Зөв хариултыг сонгоно уу.
1. Эмт бодисын дэгтэмтгий чанарыг арилгах
2. Эмт бодисыг цэвэршүүлэх
3. Эмт бодисын муухай үнэр амтыг арилгана.
4. Эмт бодисын хорыг багасгана.
5. Эмт бодисын хорыг арилгана.

/116./ Аль нь номхотгох арга вэ. Зөв хариултыг сонгоно уу.
1. Шингэн биетийг ашиглаж
2. Галын хүчийг ашиглаж
3. Гал ба шингэн биетийг ашиглаж
4. Шатаах
5. Дэвтээх

/117./ Уламжлалт монгол эмийн номхотголд хэрэглэх хатуу биет туслах материалд аль түүхий эд материалууд орох вэ. Зөв хариултыг сонгоно уу.
1. Арвай
2. Элс
3. Бал
4. Хар буурцаг
5. Буудай

/118./ Агааргүйтэний эсрэг хамгийн идэвхитэй нөлөөлөх эмийн бэлдмэлийг олно уу?
A. Ампициллин
B. Гентамицин
C. Цефоперазон
D. Метранидазол
E. Тетрациклин

/119./ Кардиоселектив бетта-адреноблокаторыг нэрлэнэ үү?
A. Пропранолол
B. Атенолол
C. Изопреналин
D. Фентоламин
E. Арфонад

/120./ Нярай хүүхдийн эмийн кинетик ба динамикийн тухай дараах мэдээллүүдийн аль нь буруу вэ?
A. Тархалтын эзлэхүүн /Vd/ бага байна
B. Эмийн хагас элиминацийн хугацаа /t1/2/ удаан байна
C. Элгэн дэх эмийн хувиралын эрчим сул байна
D. Адренорецепторууд бүрэн ялгаран хөгжиж чадаагүй байдаг
E. Эмийн клиренс удаан байна.

/121./ Дараах эмийн хослолуудаас ходоодны шархлааны эмчилгээнд хэрэглэдэг “сонгодог гурвал”-ыг олно уу?
A. Циметидин Амоксациллин Коллоид висмут
B. Ранитидин Амоксациллин Коллоид висмут
C. Метронидазол Амоксациллин Коллоид висмут
D. Алмагель Амоксациллин Коллоид висмут
E. Циметидин Метронидазол Коллоид висмут

/122./ Дараах эмүүдээс аль нь пенициллиний бөөрний сувганцарын секрецийг хориглодог вэ?
A. Диазепам
B. Гентамицин
C. Рифампицин
D. Пробенецид
E. Хинидин

/123./ Богино үйлдэлтэй бетта-2-адреномиметикийг олно уу?
A. Сальбутамол
B. Аминофиллин
C. Ипратропиум бромид
D. Орципреналины сульфат
E. Сальметерол

/124./ Уртасгасан үйлдэлтэй үрэвслийн эсрэг нөлөөт эмийг нэрлэнэ үү?
A. Аспирин
B. Анальгин
C. Пироксикам
D. Индометацин
E. Ортофен

/125./ Ямар өвчний үед пропранололыг хэрэглэж болохгүй вэ?
A. Элэгний циррозтой өвчтөнд
B. Бөөрний архаг дутагдалтай өвчтөнд
C. Гуурсан хоолойн багтраа
D. Чихрийн шижин
E. Ходоод гэдэсний шархлаатай бол

/126./ Ёс зүйн маркетингийн шинжийг тодорхойлох үзүүлэлтүүдийн аль нь зөв бэ?
1. Хэрэглэгчийн гачигдал, хэрэгцээг тогтоох
2. Илүү үр дүнтэй аргаар хэрэгцээг хангах
3. Хэрэглэгчдийн болон нийгмийн материаллаг аж байдлыг дээшлүүлэх
4. Бараа нийлүүлэлтийн бүтцийг тодорхойлох
5. Үйлчилгээний хүрээг тодорхойлох

/127./ Үйлчилгээний маркетингийн хөтөлбөр боловсруулахад харгалзах үндсэн тодорхойлолтуудад дараах зүйлийг авч үзнэ.
1. урьдчилан мэдрэх аргагүй үйлчилгээ
2. эх үүсвэрээс нь салгах боломжгүй үйлчилгээ
3. үйлчилгээний чанар нь хэлбэлзэлтэй байх үйлчилгээ
4. үйлчилгээний цар хүрээ
5. өвчтөн байхгүй үед эмч заавал байх үйлчилгээ

/128./ Маркетингийн ухааны үүднээс алийг нь ажиллаж болох ирээдүйтэй, найдвартай сегмент гэж үзэж болох вэ?
1. хэрэглэгчдийн 5 хүртэл хувь нь арилжаанд оролцож, барааных нь 50 хүртэл хувийг худалдан авч байвал
2. хэрэглэгчдийн 20 хүртэл хувь нь арилжаанд оролцож барааных нь 80 хүртэл хувийг худалдан авч байвал
3. хэрэглэгчдийн 20 хүртэл хувь нь арилжаанд оролцож, барааных нь 70 хүртэл хувийг худалдан авч байвал
4. хэрэглэгчдийн 20-с дээш хувь нь арилжаанд оролцож, барааных нь 80-с дээш хувийг худалдан авч байвал

5. хэрэглэгчдийн 10 хүртэл хувь нь арилжаанд оролцож, барааных нь 60 хүртэл хувийг худалдан авч байвал

/129./ Мөнгөн ус болон бусад хортой хүнд металл агуулсан хог хаягдлыг шар өнгийн уутанд хадгална. Тэдгээрийг асгасан тохиолдолд хориглох үйлдлийг заана уу.

1. алтан эдлэл хэрэглэж болохгүй
2. нүцгэн гараар барьж болохгүй
3. мөнгөн эдлэл хэрэглэж болохгүй
4. асгаж болохгүй
5. тусд нь цуглуулахгүй бусад хогонд нийлүүлнэ

/130./ Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад аль эмүүд орсон бэ?

1. Атенолол 50мг №30 шахмал
2. Биперидины 2мг №50 шахмал
3. Верапамилын 80 мг №20 шахмал
4. Салицилын хүчлийн 5% 30 мл-ийн уусмал
5. Хлорамфениколын 250 мг №10 капсултай эм

/131./ Зах зээлд түншлэх эмийн зах зээлийн хэлбэрүүд

1. эм зүйн алба
2. амбулатори, стационарын өвчтөн
3. барааны зах
4. эмийн бөөний төвүүд, гадаадын эмийн фирмүүд
5. ЭМЯ

/132./ Эмийн зах зээлийн иж бүрдэл судалгааны тоон тодорхойлолтод ямар асуудлууд орох вэ?

1. Эмийн хэрэглээний дундаж үзүүлэлт
2. Эмийн тусламжийн зардлын дундаж үзүүлэлт
3. Эмийн зах зээлийн багтаамж
4. Эмийн зах зээлд өрсөлдөх чадвар
5. Эмийн зах зээлийн үйлчилгээний нөхцөл

/133./ Зах зээлд нийлүүлэх эмэнд үнэ тогтооход баримтлах үндсэн баримтлал нь

1. байж болох хамгийн бага үнэ
2. хамгийн их үнэ
3. өрсөлдөгчийн ба орлох эмийн үнэ
4. импортоор авсан эмийн үнэ
5. уян хатан үнэ

/134./ MNS 5224: 2005-д зааснаар: Зарим онцгой аюултай материалын дээж авсан савны хаяглалтанд тавигдах шаардлагыг нэрлэнүү?

1. дээж болон савлагдсан материалын нэр
2. цувралын дугаар
3. дээж авсан хүний гарын үсэг
4. дээж авсан савны дугаар
5. дээж авсан он сар өдөр

/135./ Төлбөрийг нь төр хариуцан амбулатори, поликлиникээр эм олгох өвчин эмгэгт аль өвчин нь хамаарагдах вэ?

1. Хорт хавдрын 3,4-р үе шат
2. Сүрьеэ
3. Удаан хугацаанд эмчилгээ шаардагдах зарим эмгэг
4. Сэтгэцийн эмгэг
5. Хоол боловсруулах замын эмгэгүүд

/136./ Хийтэй баллон тээвэрлэж буй машины тэвшин дээр ачихыг хориглох зүйлсэд аль нь хамаарагдах вэ?

1. 1эсгий
2. органик гаралтай зүйлүүд
3. арьс шир
4. торхтой бензин шатахуун
5. хүн

/137./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хориглоно.

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шуудангаар явуулах
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг жоронд заасан хэмжээнээс илүү олгох
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг иргэн Монгол улсын хилээр нэвтрүүлэх

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг эмчилгээний бус журмаар хэрэглэх
5. Эмчилгээнд хэрэглэхийг хориглосон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдах.

/138./ Эмийн чанар муугаас дараах сөрөг үр дагавар гарна.
1. Эм хүч чадлаа алдана.
2. Эм хорт бүтээгдэхүүн болж задарна.
3. Эмчилгээний үр дүн муу байна.
4. Эмийн идэвхт бодисын тун буруу байна.
5. Эмийн стандартын шаардлага зөрчигдөнө

/139./ Аливаа аж ахуйн үйл ажиллагаанд дараах хүчин зүйлс зайлшгүй шаардагдана.
1. хэрэглэгчдийн эрэлтийг хангах
2. ашиг олох
3. нийгмийн эрх ашгийг хамгаалах
4. эрэлтийг хангаж, ашиг олох
5. хэрэглээг бий болгох

/140./ Лиценз олгогч импортын лиценз хүчингүй болгосон шийдвэрийн тухай уг шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор аль байгууллагат мэдэгдэх ёстой вэ?
1. ЭМЯ
2. Лиценз эзэмшигч
3. Зөвшөөрөл олгох комисс
4. Гаалийн байгууллага
5. Засгийн газар

/141./ Аливаа аж ахуйн нэгж фирмийн үйл ажиллагаанд нөлөөлөх маркетингийн микро орчны хүчин зүйлд аль нь орох вэ?
1. нийгэм, соёл
2. түншүүд, өрсөлдөгч
3. хүн ам зүй
4. фирмийн маркетингийн алба
5. улс төр

/142./ Зах зээл судлалын харилцааны иж бүрдэл нь юу бэ?
1. зам тээвэр, холбоо
2. зарлал чимэглэл, ухуулга сурталчилгаа
3. Интернетийн сүлжээ ашиглах
4. борлуулалтын урамшуулал, биечлэн хийх худалдаа
5. Компьютерийн сүлжээ, цахилгаан шуудан ашиглах

/143./ Барааны ангилал нь ямар асуудлуудыг шийдвэрлэхэд ач холбогдолтой вэ?
1. Эм барааны тухай мэдээллийн боловсруулалтыг автоматжуулах
2. Барааны хэрэглээний шинж чанар ба чанарыг судлах
3. Эм бараа борлуулалтыг тооцох ба төлөвлөх
4. Үнийн жагсаалт боловсруулах
5. Эмийн зах зээлийн маркетингийн судалгаа явуулах

/144./ Барааны хяналт шинжилгээнд маркетингийн дараах элементүүдийг хэрэглэнэ.
1. Барааны байгаа байдал
2. Барааны амьдралын мөчлөг
3. Барааны гурван түвшингийн аудит
4. Адил бараанаас ялгагдах шинж
5. Барааны бодит байдал

/145./ Барааны савлагаа нь ямар элементүүдээс бүрдэх вэ?
1. Сав боодол
2. Савлагааны нэмэлт хэрэгсэл
3. Хаяглалт
4. Багтаамж
5. Өнгө үзэмж

/146./ Даатгалын зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
1. эрүүл мэндийн даатгалын сангийн ашиглалт, зарцуулалтанд хяналт тавих
2. ЗШЭ-н жагсаалтад орсон даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг тогтоох
3. эрүүл мэндийн даатгалын гэрээний болон гэрчилгээний загварыг батлах
4. эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ажлын хэсэг байгуулах, тогтоол зөвлөмж гаргах
5. даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах асуудлыг шийдэх

/147./ Эмнэлгийн тусламжийн хоёрдогч шатлалын эмнэлэгт дараах эмнэлгүүд орно.
1. Сум дундын эмнэлэг
2. Аймгийн нэгдсэн эмнэлэг
3. Өрхийн эмнэлэг
4. Дүүргийн эмнэлэг
5. Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд

/148./ Төсөл хөтөлбөрийн шугамаар нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд ямар алдагдал гарсан тохиолдолд уг хохирлыг холбогдох ажилтнаар төлүүлэх вэ?
1. тээвэрлэлтийн явцад гамтсэн
2. буруу нөхцөлд хадгалж чанарыг алдагдуулсан
3. хугацаа нь дууссан эм бараа ирэх
4. үндэслэл муутай захиалга хийсэн
5. хэрэглэх явцад шаардлага хангахгүй нь илэрсэн

/149./ Амин чухал эмийн жагсаалтад аль эм нь ордог вэ?
1. Аминокапроны хүчлийн тарилгын уусмал
2. Лидокайны 2% 2мл-ийн тун шилтэй уусмал
3. Фуросемидийн шахмал
4. АТФ тарилгын уусмал
5. Прозерины тарилгын уусмал

/150./ Зах зээлийн дараах хэв шинж байна
1. Цэвэр өрсөлдөөний зах зээл
2. дангаар ноёрхохын төлөө зах зээл
3. цөөн тооны дангаар ноёрхогчдын өрсөлдөөний зах зээл
4. нийтийн зах зээл
5. цэвэр онц эрхтэй өрсөлдөөнт зах зээл

/151./ Эмийн бүртгэлийн гэрчилгээнд заавал бичигдсэн байх зүйл
1. бүртгэлийн дугаар
2. эмийн ерөнхий нэршил
3. худалдааны нэршил
4. эмийн тун хэлбэр
5. үйлдвэрлэгчийн нэр

/152./ Маркетингийн албыг дараах зарчмаар бүрдүүлнэ
1. ажилчдын ажил үүргийн зохион байгуулалтаар
2. бараа, үйлчилгээний чиглэлээр
3. газар зүйн байршлаар
4. үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр
5. мэдээллийн сүлжээгээр

/153./ Эмчилгээний зориулалттай хийгээр хангагч байгууллагын үүрэгт ал нь хамаарагдах вэ?
1. Эмчилгээний зориулалттай хий бүхий баллоныг зохих газарт аюулгүй хүргэх
2. баллоны бүрэн бүтэн байдлыг хангах
3. баллон тээвэрлэх машиныг тоноглох
4. баллоны аюулаас хамгаалах таг, штуцерийн бөглөөг зөв хийж ломбодох
5. тээвэрлэх үедээ 50-60км тутамд баллонуудын бэхэлгээг шалгах

/154./ Зах зээлийн сегментийг сонгох тоон үзүүлэлтэд дараах асуудлуудыг ашиглана.
1. Сегментийн багтаамж
2. Барааны хэмжээ
3. Барааг хэрэглэж байгаа болон боломжит хэрэглэгчдийн тоо
4. Барааны хувиарлан түгээлт
5. Барааг худалдах арга

/155./ Аж ахуйг эрхлэх бизнесийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах ямар хүчин зүйлс байх вэ?
1. Эрэлт хэрэгцээг хангах
2. Ашиг орлого олох
3. Нийгмийн эрх ашгийг хамгаалах
4. Худалдагч, худалдан авагчид болон нийгмийн сонирхолыг хослох
5. Зах зээлд баталгаатай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

/156./ Аливаа бараа энэ ойлголтод багтах эм нь зах зээлд өөрийн орших хугацаандаа амьдралын 4 мөчлөгийг туулдаг. Аль нь бэ?
1. гаралт, өсөлт
2. уналт
3. боловсролт
4. эргэлт

5. шинэчлэлт

/157./ Эмийн зах зээлийг зохицуулах улсын бодлого нь ямар арга, үндсэн зарчимд тулгуурлах вэ?

1. Хууль эрх зүйн зохицуулалт
2. Засаг захиргааны арга
3. Эдийн засгийн арга
4. Өмчийг зохицуулах
5. Хэрэглээг зохицуулах

/158./ ЭЭС-гийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулж болно. Үүнд:

1. эм худалдан авах
2. эмнэлгийн хэрэгсэл худалдан авах
3. боловсон хүчний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалтын төлбөрийг төлөх
4. ажилчдын цалин хөлсийг олгох
5. ажилчдад шагнал урамшуулал олгох

/159./ Гадаад эдийн засгийн үйл ажиллагааны барааны бүлэг, нэр төрлийг бий болгох үндсэн шалтгаан нь юу вэ?

1. Барааны ангиллыг нэг мөр болгох шаардлага
2. Үнийн тарифын зохицуулалтыг боловсронгуй болгох
3. Татвар оногдуулалт ба тарифын бус зохицуулалтыг журамлах
4. Гадаад эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэл тооцоо хөтлөх
5. .Барааны системчлэгдсэн жагсаалт код бий болгох

/160./ Эм, биобэлдмэлийн хаягдлыг дараахи аргаар устгана.

1. бага хэмжээний шингэн болон хагас шингэн хаягдлыг их усаар шингэлж бохирын шугамд
2. хаягдлыг цемент, элсээр чигжиж (хаягдал 65%, шохой 15%, цемент 15%, ус 5% харьцаагаар) бүрхүүлдсний дараа булах
3. эсэд хортой хаягдлыг 1000-1200ОС-т шатааж устгах
4. химийн хаягдлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, зааврын дагуу устгах
5. гипохлорид кальци 1:5 хэмжээтэй хийж 1 цагийн турш устгах

/161./ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллагыг заана уу?

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2. Гаалийн болон хил хяналтын байгууллага
3. Цагдаагийн байгууллага
4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5. Тагнуулын байгууллага

/162./ Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын ач холбогдол:

1. Эдийн засгийн хувьд
2. Эмийг оновчтой сонгоход
3. Эмийн нэр төрлийг тогтооход
4. Эмийн эрэлтийг нэмэгдүүлэхэд
5. Эмийн сангийн ачааллыг багасгахад

/163./ Эмийн маркетингийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дараах асуудлуудад чиглэгдэнэ

1. бүтээгдэхүүний борлуулалтыг эрчимжүүлэх
2. үйлдвэрлэлийг боловсронгуй болгох
3. бүтээгдхүүнээ боловсронгуй болгох
4. импортыг нэмэгдүүлэх
5. хувиарлалтын системийг боловсронгуй болгох

/164./ Захиалгаар нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн чанарыг баталгаажуулж дараах бичиг баримтыг ирүүлсэн байна.

1. эмийн бүтээгдэхүүний сертификат
2. цувралын сертификат
3. эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь ISO-н шаардлага хангасан тухай нотолгоо
4. хэрэглэх заавар нь Англи, Орос, Монгол хэлний аль нэг дээр бичигдсэн байна
5. шошго нь Англи, Орос, Монгол хэлний аль нэг дээр бичигдсэн байна

/165./ Тээвэрлэлт хадгалалтын онцгой горим шаардагдах вакцин, биобэлдмэл, оношлуур байдаг бөгөөд тэдгээрээс бусад барааг гаалийн агуулахаас татан авах үүргийг Эмимпэкс концерн хариуцах ба харин вакцин, биобэлдмэл, оношлуурын татан авалт, хадгалалт, тээвэрлэлтийг ХӨСҮТ гүйцэтгэнэ

/166./ Хууль болон гэрээний үндсэн дээр даатгагчид шимтгэл тогтмол төлж эрүүл мэндээ хамгаалах, учирч болох эрсдлийн зардлыг нөхөн төлүүлхээр даатгуулсан иргэнийг хэлнэ.

/167./ Коллоид уусмалын дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээ хэд вэ?
A. 1 нм
B. 1 - 100 нм
C. 0,1 – 5 мкм
D. 1 – 150 мкм
E. 150-300 мкм

/168./ Лааг өнхрүүлэх аргаар бэлтгэхдээ лааны зуурдсыг нягт уян хатан болгохын тулд ланолиныг нэмэхдээ яаж тооцож авах вэ?
A. 30 гр зуурдсанд 1 гр ланолин байхаар тооцож авна
B. 45 гр зуурдсанд 1 гр ланолин байхаар тооцож авна
C. 30 гр зуурдсанд 3 гр ланолин байхаар тооцож авна
D. 20 гр зуурдсанд 1 гр ланолин байхаар тооцож авна
E. 30 гр зуурдсанд 2 гр ланолин байхаар тооцож авна

/169./ Нүдний хальсан бэлдмэлийн зөв хариултыг сонгоно уу? Зөв хариултыг сонгоно уу?
A. Зууван хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионийцэлтэй ариутгагдсан эмийн хэлбэр юм.
B. Тэгш хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.
C. Зууван хэлбэртэй, 6-9мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.025гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.
D. Зууван хэлбэртэй, тэгш өнцөгтэй 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шигэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

/170./ 1 гр бодисын уусахад 1 мл хүртэл уусгагч шаардагддаг бол тухайн бодис уусалтаараа ямар ангилалд хамаарагдах вэ?
A. Маш амархан уусдаг
B. Амархан уусдаг
C. Уусдаг
D. Аажим уусдаг
E. Маш муу уусдаг

/171./ Агаарын босоо ламинар урсгалын хурд хэд байдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 0,1м/сек
B. 0,5м/сек
C. 0,3м/сек
D. 0,6м/сек
E. 0,45м/сек

/172./ 10% -ийн натрийн тетраборатын 10 мл нүдний дусал нь нулимсны шингэний хувьд ямар уусмал байх вэ? (натрийн хлоридын изотоник эквивалент 0.34 )
A. Гипотоник
B. Изотоник
C. Гипертоник
D. изоионик
E. Гипоионик

/173./ Ердийн дусал хэмжигчийн гадна болон дотор диаметрийг заана уу?
A. 3.6 мм ба 0.5 мм
B. 3 мм ба 1 мм
C. 3.5 мм ба 0.6 мм
D. 3 мм ба 0.6 мм
E. 3.2 мм ба 0.5 мм

/174./ Нүдний тосон суурийг жоронд заагаагүй бол, ямар тосон суурь авах вэ?
A. вазелины тосон суурь
B. вазелин, ланолины 10:1 харьцаатай тосон суурь
C. вазелин, ланолины 1:1 харьцаатай тосон суурь
D. ланолин
E. силиконы суурь

/175./ Ариун бүтээгдэхүүн үйлдвэрлэх агаарын цэвэршилтийн В,С, Д зэрэглэлд хүрэхийн тулд агаарын солилцооны хэмнэл нь хэд байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 1 цагт 10-15
B. 1 цагт 20-с дээш

C. 1 цагт 15-с дээш
D. 1 цагт 10 дээш
E. 1 цагт 5-аас дээш

/176./ Аэрозолийн баллон хэдий хэмжээний илүүдэл даралтыг даах чадвартай вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 4-5 атм
B. 2-3 атм
C. 5-7 атм
D. 2-8 атм
E. 3-7 атм

/177./ Дараах холимог шингэн эмийг бэлтгэхэд холих зөв дараалалыг заана уу?
Кодейн 0.12
Натрийн бромид 4.0
Натрийн гидрокарбонат 4.0
Гуа хатны хандмал 5 мл
Бамбайн хандмал 20 мл
Нэрмэл ус 200 мл
A. Нэрмэл ус®Натрийн бромидын аагтай уусмалыг нэмнэ®Натрийн гидрокарбонатын аагтай уусмалыг нэмнэ ® Кодейныг хэмжиж аваад уусгаж шүүнэ ® Гуа хатны хандмалыг нэмнэ®Бамбайн хандмалыг нэмнэ
B. Нэрмэл ус®Гуа хатны хандмалыг нэмнэ®Бамбайн хандмалыг нэмнэ ® Натрийн бромидын аагтай уусмалыг нэмнэ®Натрийн гидрокарбонатын аагтай уусмалыг нэмнэ ® Кодейныг хэмжиж аваад уусгаж шүүнэ
C. Кодейныг хэмжиж аваад нэрмэл усанд уусгаж олгох шилэнд шүүнэ.® Гуа хатны хандмалыг нэмнэ®Бамбайн хандмалыг нэмнэ®Натрийн бромидын аагтай уусмалыг нэмнэ®Натрийн гидрокарбонатын аагтай уусмалыг нэмнэ
D. Кодейныг хэмжиж аваад нэрмэл усанд уусгаж олгох шилэнд шүүнэ.®Натрийн бромидын аагтай уусмалыг нэмнэ®Натрийн гидрокарбонатын аагтай уусмалыг нэмнэ ®Гуа хатны хандмалыг нэмнэ®Бамбайн хандмалыг нэмнэ
E. Нэрмэл ус®Натрийн бромидын аагтай уусмалыг нэмнэ® Кодейныг хэмжиж аваад уусгаж шүүнэ ®Натрийн гидрокарбонатын аагтай уусмалыг нэмнэ® Гуа хатны хандмалыг нэмнэ®Бамбайн хандмалыг нэмнэ

/178./ Хуурай халуун агаараар ариутгах процесс юунд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Ариутгах камерт хуурай халуун агаар эргэлдэж байхад үндэслэгдэх ба гаднаас агаар орохоос сэргийлэхийн тулд нэмэлт даралтыг камерт барьж байх ёстой
B. Ариутгах камераас агаарыг гадагшлуулахад үндэслэгддэг
C. Ариутгалд хэрэглэгдэж буй уур нь өндөр даралттай байх ёстой
D. Ариутгах камерт халуун уур оруулахад үндэслэгддэг
E. Ариутгах камерт халуун агаар оруулах хэрэгтэй

/179./ Хөвмөл эмийн хэлбэрт дисперсийн фазын тогтвортой чанар нь ямар хэмжигдэхүүнтэй шууд хамааралтай байдаг вэ?
A. Жижиг хэсгийн хэмжээ
B. чөлөөт уналтын хурдатгалтай
C. Дисперсийн фаз ба орчны нягтын ялгавартай
D. дисперсийн орчны зуурамтгай шинж чанартай
E. Эмийн бодисын хадгалах хугацаатай

/180./ Нунтгийн урсах чанар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?
A. Нунтаг эмийн бодисын урсах чанар
B. Нунтаг бодисын гоожих чадвар
C. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт урсах чадвар
D. Нунтаг бодис нь өөрийнхөө хүндийн жингээр гоожих чадвар
E. Тодорхой эзэлхүүнтэй нунтгийн урсах чанар

/181./ Хэрэв тосон түрхэцийн найрлаганд орсон эмийн бодисын хэмжээ 5%-аас бага байвал сууриндаа яаж оруулах вэ?
A. Суурийн хагасыг хайлуулж хольж нунтаглаад үлдсэн суурийг дээрээс нь нэмнэ.
B. Сайтар нунтаглаад суурьтайгаа холино
C. Туслах шингэн бодистой хольж жижиглээд дараа нь үлдсэн суурь бодистой холино.
D. Бүх сууриа хайлуулж дээрээс нь урьдчилан жижиглэсэн эмийн бодисоо жигд цацаж бэлтгэнэ.
E. Эмийн бодис дээрээ хайлуулсан сууриа нэмж холино.

/182./ Бөмбөлөгт тээрэмд жижиглэх гэж буй материалыг бөмбөлөгүүдийн хамт хийхдээ хүрдний эзлэхүүний хэдэн хувьд хийдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 60%
B. 30%
C. 40-45%
D. 50%
E. 30-35%

/183./ Нунтгийн асгарах жин гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?
A. Чөлөөтэй асгарах нунтгийн нэгж эзэлхүүн дэх жинг хэлнэ.
B. Нунтаг бодисын хүндийн жинг хэлнэ.
C. Нунтаг бодисын хувийн жинг хэлнэ.
D. Чөлөөтэй асгарах нунтгийн жинг хэлнэ.
E. Нунтаг бодисын нягтыг хэлнэ.

/184./ Ариун эмийн үйлдвэрлэлийн “Д” зэрэглэлд ажилчдад ямар шаардлага тавих вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Үсийг, боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, хамгаалалтын хувцас тэдгээрт тохирсон гутал өмссөн байх
B. Үсийг, боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, өмд цамцны хослол 1 эсвэл 2 ширхэг байх
C. Толгойн өмсгөл нь үсийг бүрэн далдалсан байх
D. Өдөр бүр ариутгасан шинэ хувцас өмсөх
E. Усанд орсон байх

/185./ Нүдний тосон түрхэцийг бэлтгэхдээ яагаад вазелин дээр ланолин ба усыг нэмдэг вэ?
A. Эмийн бодисын шимэгдэлтийг түргэсгэхийн тулд
B. Эмийн бодисыг суурьтайгаа сайн холихын тулд
C. Эмийн бодисын үйлчилгээг удаашруулахын тулд
D. эмийн хэлбэрийг тогтворжуулахын тулд
E. Эмийн бодисыг уусгахын тулд

/186./ Тритурацийг ямар харьцаагаар бэлтгэдэг вэ?
A. 1:1, 1:2
B. 1:10, 1:100
C. 1:1, 1:10
D. 1:50, 1:100
E. 1:5, 1:10

/187./ Цийдмэгийн дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээ хэд вэ?
A. 1 нм
B. 1 - 100 нм
C. 0,1 – 5 мкм
D. 1 – 150 мкм
E. 150-300 мкм

/188./ Тун шилний дотор талыг ямар аргаар угаах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Химийн
B. Физикийн
C. Тариурын
D. Конденсацын
E. Биологийн

/189./ Цувралын дугаар гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдсон бүх баримт бичгийн дугаар юм.
B. Дугаарлах хэсгийг тодорхойлж бичсэн зөв ажиллагааны заавар юм
C. Бүтээгдэхүүний хаяган дээрх цуврал, цувралын бүртгэл, шинжилгээний сертификат зэрэгт бичигдсэн тусгайлан танигддаг тоо буюу үсгээс тогтсон илэрхийлэл юм. Хэсэг бүтээгдэхүүнийг бусад бүтээгдэхүүнээс ялгах зорилгоор тусгайлан тавьсан хяналтын дугаар юм.
D. Үйлдвэрлэлийн бүх дамжлагыг дамжсан гэдгийг нотолсон дугаар
E. Эцсийн савлалтаас гадна үйлдвэрлэлийн бүх дамжлагын бүтээглэхүүнийг хамарсан дугаар

/190./ Холимог шингэн эм бэлтгэхэд усыг ямар зорилгоор эхлээд хийдэг вэ?
A. Сулруулсан уусмал гарган авах зорилгоор
B. Нэгэн төрлийн уусмал болгох зорилгоор
C. Ингредиентүүдийн харилцан үйлчлэлээс сэргийлэх
D. уусгагчийн алдагдлыг багасгах
E. Уусах бодис, уусмалын хэмжээг алдагдуулахгүйн тулд

/191./ Хөвмөлийн дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээ хэд вэ?
A. 1 нм
B. 1 - 100 нм

C. 0,1 – 5 мкм
D. 1 – 150 мкм
E. 150-300 мкм

/192./ Хөвөн ба самбайн оронд хэрэглэдэг шилэн шүүлтүүрийн хэмжээг заана уу.
A. нүхний голч нь 90-120 мкм
B. нүхний голч нь 150-200 мкм
C. нүхний голч нь 40-150 мкм
D. нүхний голч нь 5-15 мкм
E. нүхний голч нь 15-40 мкм

/193./ Цардуулын цавуу бэлтгэхэд цардуулыг ямар байдлаар халуун усанд оруулах вэ?
A. хуурай байдлаар
B. суспенз байдлаар
C. эмульс байдлаар
D. комплекс байдлаар
E. тосон уусмалаар

/194./ Дамжин бохирдох гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Нэг бүтээгдэхүүний эхлэл материал, дамжлагын бүтээгдэхүүн эсвэл бэлэн бүтээгдэхүүн нь өөр бүтээгдэхүүний эхлэл материал болон үйлдвэрлэлийн явцын материалаар бохирдохыг хэлдэг
B. Үйлдвэрлэлийн явцад завсрын ба эцсийн бүтээгдэхүүн нь өөр бусад эхний материал ба эцсийн бүтээгдэхүүнээр бохирдохыг хэлнэ
C. Эцсийн савлалт, хаяглалтыг оруулан үйлдвэрлэлийн бүх шатны бохирдолтыг хэлнэ.
D. Эмийн бүтээгдэхүүний чанарын өөрчлөлтийн шалтгаан нь болдог процесс юм
E. эхний материал, эцсийн савлалт, хаяглалт зэрэг нь үйлдвэрлэлийн бүх бүтээгдэхүүнийг бохирдуулахыг хэлнэ

/195./ Шахмал эмийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг туслах бодисын нийт хэмжээ ямар байх ёстой бэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. 5%-иас ихгүй
B. 7% иас ихгүй
C. 10% иас ихгүй
D. 20% иас ихгүй
E. 25% иас ихгүй

/196./ Тарилгын зориулалттай уусгагчид тавих шаардлага ямар байх вэ? Зөв хариултыг сонгоно уу?
A. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай, физик-химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой байхаас гадна үнэ хямдтай байвал тохиромжтой
B. Уусгагч нь уусгах чадвар сайтай, хадгалах явцад тогтвор сайтай, физик- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, амархан хөлддөг, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх шаардлагатай.
C. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай физмк- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой өндөр үнэтэй байх шаардлагатай.
D. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвор сайтай физмк- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордог, фармакологийн хувьд идэвхгүй, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх хэрэгтэй.
E. Уусгагч нь маш сайн уусгах чадвартай, хадгалах явцад тогтвортой, физмк- химийн хувьд эмийн бодистой харилцан үйлчлэлд ордоггүй, фармакологийн хувьд идэвхгүй, өндөр температурт хайлдаг, хэрэглэхэд тохиромжтой үнэ хямд байх хэрэгтэй.

/197./ Усан уусмалыг бэлтгэхэд уусах процессыг хурдасгахад ямар үйлдлийг хийдэггүй вэ?
1. Уусдаг давс үүсгэх процесс
2. Халаах
3. Урьдчилан жижиглэх
4. Хэсэгчилж фракцлах
5. Комплекс нэгдэл үүсгэх

/198./ Хөвмөл хэлбэрийн тосон түрхцэн дэх эмийн бодисын жижиглэлтийн хэмжээг микроскопын тусламжтайгаар тодорхойлоход дараах шаардлагыг хангасан байх ёстой.
1. Германы фармакопейд тосон түрхцэн дэх эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ 60 мкм-ээс томгүй, нүдний тосон түрхцэнд-50 мкм-ээс томгүй байх ёстой.
2.АНУ-д нүдний тосон түрхцэн дэх эмийн бодисын хэмжээ 50 мкм-ээс томгүй байх ёстой.
3. ОХУ-д тосон түрхцэнд 50 мкм-ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна
4. Босины аргаар тодорхойлоход 60 мкм- ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна.
5. Чулковын аргаар тодорхойлоход 60 мкм- ээс томгүй хэсгүүд 3%-иас хэтрэхгүй байна

/199./ Үл нийцлийг засах ямар арга замууд байж болох вэ?
1. Эмийн бодисыг тохирох фармакологийн аналогоор нь орлуулах
2. Технологийн онцгой үйлдлийг хэрэглэх
3. Нэг эмийн хэлбэрийг нөгөөгөөр нь солих
4. Үл нийцэл үүсгэж байгаа бодисыг хасах
5. Жорноос А ба Б дансны бодисыг тусад нь олгох

/200./ Зуурамтгай шинж чанартай уусгагч бүхий уусмалыг бэлтгэх ямар онцлог байдаг вэ?
1. Жингийн аргаар бэлтгэх
2. Ариутгасан хуурай олгох шилэнд халаах замаар уусгана.
3. Шаардлагатай бол хоёр давхар самбайгаар шүүнэ.
4. Жин-эзэлхүүний аргаар бэлтгэх
5. Халаах шаардлага гардаг учир хуурай шилэнд уусгана.

/201./ Гетероген тосон түрхэцэд ямар тосон түрхэцүүд хамаарагдах вэ?
1. суспенз хэлбэрийн тосон түрхэц
2. эмульс хэлбэрийн тосон түрхэц
3. хосолсон хэлбэрийн тосон түрхэц
4. уусмал хэлбэрийн тосон түрхэц
5. хайлш хэлбэрийн тосон түрхэц

/202./ Жинхэнэ уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?
1. Гадна байдал нь тунгалаг
2. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
3. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрнэ.
4. Тогтвор сайтай
5. Жижиг хэсгүүд нь мембранаар нэвтэрнэ.

/203./ Хийн ариутгалын аргад хэрэглэгддэг хиинүүдэд аль нь хамаарагдах вэ ?
1. Этилений оксид
2. пропилений оксид
3. b-пропиолактон
4. полиэтиленоксид
5. пропиленгликоль

/204./ Үрэлд ямар зорилгоор туслах бодисуудыг нэмдэг вэ?
1. үрэл эмэнд жин багтаамж олгох зорилгоор
2. үрэлд уян хатан байдал олгох зорилгоор
3. үрэлд хэлбэр дүрс олгох зорилгоор
4. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг ихэсгэх зорилгоор
5. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг хурдасгах зорилгоор

/205./ Хөвмөлийн шинж чанарыг нэрлэнэ үү?
1. Гадна байдал нь тунгалаг
2. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрэхгүй.
3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
4. Гэрлийг ойлгож,хугалсны дүнд сарниулна
5. ердийн микроскопонд харагдахгүй.

/206./ Тосон түрхэцээс эмийн бодис шимэгдэх процессыг сайжруулах сууринд ямар суурь хамаарагддаг вэ?
1. Вазелин
2. Ланолин ургамлын тостой холимог
3. Силиконон суурь
4. Констентны эмульсэн суурь ус/ вазелин
5. Загасан тос

/207./ Хөвмөлийн тогтвортой чанар нь дараах хэмжигдэхүүний аль алинтай нь урвуу пропорциональ хамааралтай вэ?
1. Жижиг хэсгийн диаметртэй
2. Хүндийн хүчний хурдатгалтай
3. Дисперсийн орчин ба дисперсийн фазын нягтын ялгавартай
4. Орчны зуурамтгай чанартай
5. Дисперсийн фазын шинж чанар

/208./ Дараах шингэнүүдээс аль нь шокийн эсрэг гемодинамикийн шингэнд хамаарагдах вэ?
1. Аминопептидын уусмал
2. Полиглюкин
3. Рингер-Локкын уусмал
4. Реополиглюкин

5. Гемодез

/209./ Нунтаг эмийн бодисыг холиход хамгийн түрүүнд уурандаа ямар бодисыг эхэлж авах ёстой вэ?

1. Саармаг чанарын бодисыг авна.
2. Саармаг чанарын бодис байхгүй бол их хэмжээтэй бичигдсэн бодисоос авна.
3. Жижиглэхэд бэрхшээлтэй бодисуудыг эхэнд нь авна.
4. Багаас нь их рүү гэсэн зарчмын дагуу хамгийн бага хэмжээтэй бодисыг эхэлж жижиглэнэ.
5. Талст устай бодисуудыг эхлээд авч хатаана.

/210./ Жоронд эмийн бодисын тун хэтэрсэн тохиолдолд яах вэ?

1. Тусгай тэмдэглэл байвал бэлтгэж болно.
2. Эмийн бодисын нэг удаагийн дээд тунгийн хагасыг олгоно.
3. Мансууруулах бодисын эмийн тунгийн тоог багасгаж олгох нормоос нийлбэр тун нь ихгүй байхаар олгоно.
4. Жорыг олгохгүй.
5. Эмчтэй нь зөвлөж шийднэ.

/211./ Ханасан уурын даралтын дор автоклаваар ямар зүйлүүдийг ариутгаж болох вэ ?

1. Шил,металл, шаазан эдлэл
2. эмний шил, колбо, юүлүүр, уур, нүдүүр
3. Ороох боох зүйлүүд
4. Өндөр температурт тогтвортой бодисын уусмал
5. пергаментэн цаас, халат, хувцас

/212./ Усан ялгамал бэлтгэхэд хандлах процессын үндсэн үе шатуудад дараах хүчин зүйлүүдээс аль нь хамаарагдах вэ?

1. Түүхий эдийг норгох / капиллярын шингээлт/
2. Хандлалт явуулах
3. ялгамлыг гоожуулж авах
4. Диализ
5. Десорбц

/213./ Дараах ямар тохиолдолд конденсацын арга нь хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд хэрэглэгддэг вэ?

1. Дисперсийн орчинд эмийн бодис нь уусахгүй тохиолдолд
2. Уусгагчийг солих
3. Уусалтыг сайжруулах
4. Химийн урвалын үр дүнд тунадас үүсэх
5. Коалесценц

/214./ Идээшмэл чанамалын тунг хэрхэн шалгах вэ?

1. Нэг удаагийн тунг олохдоо түүхий эдийн хэмжээг шингэн эмийг хэдэн удаа хэрэглэх тоонд харьцуулж гаргана.
2. Хоногийн тунг шалгахдаа 1 удаагийн тунг хоногт хэрэглэх тоогоор үржүүлнэ
3. Фармакопейн заалттай харьцуулж үзнэ.
4. Нэг удаагийн тунг олохдоо бэлдэх ялгамлын нийт эзэлхүүнийг эмийг хэдэн удаа хэрэглэх тоонд харьцуулж гаргана.
5. Хоногийн тунг шалгахдаа түүхий эдийн хэмжээг хэдэн удаа хэрэглэх тоогоор үржүүлнэ

/215./ Хүчтэй суурь, сул хүчлийн үлдэгдлээс тогтсон эмийн бодисыг тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Давсны хүчил
2. Натрийн шүлт
3. Вейбелийн тогтворжуулагч
4. Натрийн гидрокарбонат
5. Этилендиаминтетра-цууны хүчил

/216./ Усыг нэрэхэд бэлтгэх үйл явцыг заана уу.

1. усыг тунгаах
2. усыг зөөлрүүлэх
3. коллойд хольцыг бүлэгнүүлж ялгах
4. аммиакийг холбож цэвэрлэх
5. органик хольцыг задалж цэвэрлэх

/217./ Мөхлөгжүүлэх процессын зөв тодорхойлолт аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

А. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах, үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.

B. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг бууруулан үелэхээс сэргийлэх зорилгоор нунтаг эмийн бодисыг тодорхой хэмжээний үр шиг болтол нь жижиглэх процессыг хэлнэ

C. Мөхлөгжүүлэх процесс гэдэг нь шахмал хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор нунтаг эмийн бодисыг томруулах процессыг хэлнэ.

D. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх нунтаг эмийг үр шиг болтол нь томруулах процессыг хэлнэ.

E. Мөхлөгжүүлэх процесс гэж шахмалын масс хийх массын урсах чанарыг сайжруулах зорилгоор эмийн бодисыг нунтаглах процессыг хэлнэ.

/218./ Ариутгалын дараа туншилний бүрэн бүтэн байдлыг шалгахдаа тун шилтэй уусмалыг ямар уусмалд хийж шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Савангийн уусмал

B. Нэрмэл ус

C. 0.0005% метилен хөхийн уусмал

D. 0.9% натрийн хлоридын уусмал

E. Спиртийн уусмал

/219./ Хуурай халуун агаараар ариутгах процесс юунд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Ариутгах камерт хуурай халуун агаар эргэлдэж байхад үндэслэгдэх ба гаднаас агаар орохоос сэргийлэхийн тулд нэмэлт даралтыг камерт барьж байх ёстой.

B. Ариутгах камераас агаарыг гадагшлуулахад үндэслэгддэг

C. Ариутгалд хэрэглэгдэж буй уур нь өндөр даралттай байх ёстой

D. Ариутгах камерт халуун уур оруулахад үндэслэгддэг

E.Ариутгах камерт халуун агаар оруулах хэрэгтэй

/220./ Үйлдвэрийн ердийн гэрэлтүүлэг хэд вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 450 люкс

B. 350 люкс

C. 300 люкс

D. 265 люкс

E. 500 люкс

/221./ Туншилний бүрэн байдлыг шалгахдаа ямар уусмалд хийж шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Спиртийн уусмалд

B. Хлорамины уусмалд

C. Нэрмэл усанд

D. Метилен хөхийн уусмалд

E. Фурациллины уусмалд

/222./ Бактерцидны лампыг ажил эхлэхээс хэдэн цагийн өмнө ажиллуулах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 2-4

B. 3-4

C. 1-2

D. 2-3

E. 4-6

/223./ Нүдний хальсан бэлдмэлийн зөв хариултыг сонгоно уу? Зөв хариултыг сонгоно уу?

A. Зууван хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионийцэлтэй ариутгагдсан эмийн хэлбэр юм.

B. Тэгш хэлбэртэй, 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

C. Зууван хэлбэртэй, 6-9мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.025гр дундаж жинтэй нулимасны шингэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

D. Зууван хэлбэртэй, тэгш өнцөгтэй 9-6мм-ийн урт, 3.0-4.5мм өргөн, 0.35мм-ийн зузаантай 0.015гр дундаж жинтэй нулимасны шигэнтэй бионицэлтэй нүдний эмийн хэлбэр юм.

/224./ Хэрэв тусгайлсан заалт байхгүй бол бүрхүүлтэй шахмал эм ямар хугацаанд задрах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 15мин-с ихгүй

B. 30мин-с ихгүй

C. 5мин-с ихгүй

D. 10мин-с ихгүй

E. 3 мин-с ихгүй

/225./ Дамжин бохирдох гэж юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Нэг бүтээгдэхүүний эхлэл материал, дамжлагын бүтээгдэхүүн эсвэл бэлэн бүтээгдэхүүн нь өөр бүтээгдэхүүний эхлэл материал болон үйлдвэрлэлийн явцын материалаар бохирдохыг хэлдэг

B. Үйлдвэрлэлийн явцад завсрын ба эцсийн бүтээгдэхүүн нь өөр бусад эхний материал ба эцсийн бүтээгдэхүүнээр бохирдохыг хэлнэ

C. Эцсийн савлалт, хаяглалтыг оруулан үйлдвэрлэлийн бүх шатны бохирдолтыг хэлнэ.

D. Эмийн бүтээгдэхүүний чанарын өөрчлөлтийн шалтгаан нь болдог процесс юм

E. Еэхний материал, эцсийн савлалт, хаяглалт зэрэг нь үйлдвэрлэлийн бүх бүтээгдэхүүнийг бохирдуулахыг хэлнэ

/226./ Хатуу капсулд глицерин хэдэн хувь агуулагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. 0,2-0,25%

B. 0,3% хүртэл

C. 20-25%

D. 2-5%

E. 0,5% хүртэл

/227./ Ариун эмийн үйлдвэрлэлийн “Д” зэрэглэлд ажилчдад ямар шаардлага тавих вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Үсийг, боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, хамгаалалтын хувцас тэдгээрт тохирсон гутал өмссөн байх

B. Үсийг, боломжтой бол сахлыг ил гаргахгүй битүү далдалсан, өмд цамцны хослол 1 эсвэл 2 ширхэг байх

C. Толгойн өмсгөл нь үсийг бүрэн далдалсан байх

D. Өдөр бүр ариутгасан шинэ хувцас өмсөх

E. Усанд орсон байх

/228./ Контактны хатаагчид аль нь хамаарах вэ?

A. Вакуум хатаагч шүүгээ

B. Шүүгээт хатаагч

C. Вакуум булт хатаагч

D. Туузан хатаагч

E. Өндөр давтамжит цахилгаан гүйдлээр хатаагч

/229./ Шулуун гэдэсний капсулын бүрхүүлийг бэлтгэхдээ дараах бодисуудыг ямар харьцаагаар бэлтгэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Желатин 20% ,глицерин 10%

B. Желатин 1 хэсэг, глицерин 3хэсэг, ус 5 хэсэг

C. Желатин 3 хэсэг, глицерин 1 хэсэг, ус 5 хэсэг

D. Желатин 70% ,глицерин 30%

E. Желатин 1хэсэг,глицерин 5 хэсэг,ус 4 хэсэг

/230./ Тарилгын зориулалттай нэрмэл усны чанарыг сайжруулах, пироген бодисгүй болгохын тулд технологийн ямар шийдлийг сонгох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Усыг нэрэхдээ 1100-аас дээш температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар явуулна

B. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулахгүйгээр тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна

C. Усыг нэрэхдээ менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар задгай буцалгаж нэрнэ.

D. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тохиромжтой хурдтайгаар, гадаргуугийн усны дусал үүсгэхгүй байхаар нэрэлтийг явуулна

E. Уснаас гадаргуугийн идэвхт бодис, менерал давс, хөөс үүсгэгч бодисуудыг урьдчилан зайлуулсны дараа тогтмол температурт, тогтмол бус хурдтайгаар нэрэлтийг явуулна.

/231./ Тун шилний дотор талыг ямар аргаар угаах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

A. Химийн

B. Физикийн

C. Тариурын

D. Конденсацын

E. Биологийн

/232./ Ямар тохиолдолд хэвлэх аргаар шахмалыг гарган авдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Эмийн бодисын туналалт маш бага байх тохиолдолд туслах бодисыг бага хэмжээгээр нэмэх үед
2. Уусмал бэлтгэх зориулалтын шахмал хийх тохиолдолд
3. Даралтын нөлөөгөөр эмийн бодис нь ямар нэгэн өөрчлөлтөнд орох үед
4. Шахмал хийх масс нь чийг их татдаг байвал

5. Шахмал хийх масс нь шахмал болохгүй бутрах эсвэл бат бэх биш шахмал үүсгэх үед

/233./ Шууд шахах аргаар шахмал эм гарган авахад нунтаг эмийн бодис нь ямар шинж чанартай байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Урсах чанар сайтай
2. Шахагдах чанар сайтай
3. Тодорхой чийглэгтэй байх
4. Асгарах жин сайтай байх
5. Фракцын бүрэлдэхүүн сайтай байх

/234./ Ямар шалтгааны улмаас эмийн бодисыг микрокапсул эмийн хэлбэрт оруулдаг вэ?. Зөв хариултыг сонгоно уу?

1. Хий болон шингэн байдалтай эмийн бодисыг хуурамч хатуу байдалд оруулах
2. Тогтвор муутай эмийн бодисыг гадны хүчин зүйлээс хамгаалах
3. Эмийн бодисын цочроох болон гаж үйлдлийг багасгах
4. Эмийн бодисын үйлдлийг ходоодны хүчиллэг орчноос хамгаалах
5. Туулгах зорилготой

/235./ Үрэл эмийн хэлбэрийг өнгөлөхөд ямар бодис ордог вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Тальк
2. Лав
3. Ургамлын тос
4. Сахарын пудр
5. Метилцеллюлоз

/236./ Хурилтуурдах арга нь ямар зарчимд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хагас нэвтрүүлэгч мембраны үйлчлэлээр
2. Хүндийн хүч болон инерцийн хүчний үйлчлэлээр
3. Даралтын хүчний нөлөөгөөр
4. Төвөөс зугтах хүчний үйлчлэлээр
5. Төв үү чиглэлтэй хүчний нөлөөгөөр

/237./ Үйлдвэрлэлийн байрыг ямар ямар бүс болгон хувааж үздэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Цагаан бүс
2. Саарал бүс
3. Хар бүс
4. Ногоон бүс
5. Цэнхэр бүс

/238./ Агаарын хийн урсгалын тусламжтайгаар нунтаглагч тээрмийн ажиллагаанд аль нь хамааргдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Жижиглэлтийг холих, хатаах процесстой хамт явуулах боломжтой
2. Маш нарийн коллойд нунтаг гарган авах боломжтой
3. Агаарын урсгалын дэглэмийг нарийн чанд баримтлах шаардлагатай.
4. Бэлэн бүтээгдэхүүн нь нунтаглагчийн эд ангиас үүсэлтэй зүйлээр бохирддоггүй сайн талтай.
5. Энерги их зарцуулдаг.

/239./ Ингаляцийн аэрозольд ямар уусгагчийг хэрэглэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Ургамлын тос
2. Этанол
3. Ус
4. Этилацетат
5. Ацетон

/240./ Тосон түрхлэгийг яаж стандартчлах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Нэгэн төрөл байдал
2. Тосон түрхцийн консистенц буюу бүтцийн механик чанар
3. Агуулагдах бодисын тоон үзүүлэлт
4. Хадгалах явцад тогтвортой байх чанар
5. Эмийн хэлбэрээс эмийн бодис чөлөөлөгдөх хугацаа

/241./ Туншилийг ямар аргаар гагнадаг арга? Зөв хариултыг сонгоно уу?

1. Вакумын арга
2. Хайлуулж гагнах арга
3. Дулааны арга
4. Сунгаж гагнах арга
5. Зүсж гагнах арга

/242./ Олон үет шахмалын давуу тал нь юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. 1 Үл нийцдэг эмийн бодисуудыг нэг эмийн хэлбэрт оруулах боломжтой
2. Эмийн бодисын үйлчилгээг удаашруулах

3. Эмийн бодисын шимэгдэлтийг зохицуулах
4. Усанд уусдаг болон уусдаггүй туслах бодисыг агуулдаг
5. Эмийн бодисын үйлчилгээг хурдасгадаг

/243./ Шахмал эмийн хэлбэрийн давуу талд аль нь орох вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Хадгалах явцад задралт нь удааширдаг.
2. Хадгалах явцад хатуурч цемент шиг болдог.
3. Бүх өвчтөнгүүдэд хэрэглэж чаддаггүй
4. Нарийн туналагдсан
5. Концентрацтай уусмал үүсч салстыг цочроодог.

/244./ Каучукан гоюу үйлдвэрлэх технологийн процессын үе шатанд аль нь хамааргдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Гоюуны массыг даавуун материал дээр түрхэж, хатаах
2. Ороох, зүсэх ба чанарыг нь шалгах
3. Савлах
4. Цаасан дээр массыг жигд түрхэх
5. Хэлбэржүүлэх

/245./ Бүтээгдэхүүний материалын орцыг зохиоход ямар үзүүлэлтүүдийг гол үзүүлэлт болгон авах бэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Үйлдвэрийн алдагдал
2. Бэлэн бүтээгдэхүүний хэмжээ
3. Хаягдал бүтээгдэхүүний хэмжээ
4. Эхлэл материалын хэмжээ
5. Дагалдах бүтээгдэхүүний хэмжээ

/246./ Зөөлөн капсулд ямар консистенцтэй эмийн бодисыг дүүргэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Өтгөвтөр шингэн
2. Шингэн
3. Паст
4. Өтгөн
5. Зуурамтгай

/247./ Жижиглэх процессын дүнд хатуу биетийн гадаргуугийн талбай ихэсдэг. Тийм учраас бодисыг жижиглэх процессын онолын үндэс нь зөвхөн гадаргуугаар жижиглэгддэг гэж үздэг.

/248./ Шахмалын гадаад байдлыг сайжруулах зарим хортой, хүчтэй наркотик эмийг ялгах зорилгоор янз бүрийн хүнсний будаг ашигладаг. Учир нь ямарч ялгагдах зүйлгүй бүгд цагаан өнгийн шахмал байх нь тохиромжгүй.

/249./ Хатуу желатинан капсулыг гарган авахдаа дуслын аргыг хэрэглэдэг. Учир нь тогтмол температуртай желатины уусмалд тэнхлэгээрээ эргэлдэх олон тооны металл хэвийг дүрээд авахдаа капсул хэлбэр үүсгэхэд үндэслэгддэг.

/250./ Бүрхүүл үүсгэгч нь тодорхой хэмжээний бат бөх, уян хатан шинж чанартай байх ёстой. Учир нь бүрхүүлд савлагдсан эмийн чанар байдал, эмчилгээний үр дүн нь бүрхүүлийн шинж чанараас шууд хамаарна.

/251./ Мөхлөг нь олон төрлийн фракцын бүрэлдэхүүнтэй байж болохгүй. Учир нь тэдгээр нь үелэн шахмалын дундаж жинд муугаар нөлөөлдөг.

/252./ Зөвхөн шинэ галены бэлдмэлийн үйлдвэрлэлд ашиглагдах үе шатыг заана уу
A. Түүхий эд экстрагентийг бэлтгэх
B. Хандлах
C. Цэвэрлэх
D. Техникийн бэлэн бүтээгдэхүүн гаран авах
E. Стандартчилах

/253./ 50 мл бамбайн үндэсний 1:5 хандмалыг перколяцын аргаар гаргахад хэдэн мл 70% этанолыг экстрагент болгон авах вэ? К=1.5
A. Түүхий эд 50 г-ыг авч 130 мл 70% этанолоор хандална.
B. Түүхий эд 10 г. авч 65 мл 70% этанолоор хандална.
C. Түүхий эд 5г-ыг авч перколяторт хийгээд 57.5 мл 70% этанолоор хандална.
D. Түүхий эд 100 г-ыг авч 180 мл 70% этанолоор хандална.
E. Түүхий эд 50 г-ыг авч 70 мл 70% этанолоор хандална.

/254./ Диффузлэгдэх бодисын хэмжээтэй урвуу хамааралтай үзүүлэлтийг заах
A. Фазыг зааглагч гадаргуу
B. Диффузи явагдах үеийн зузаан
C. Концентрацийн ялгаа
D. Диффузи явагдах хугацаа
E. Диффуззийн коффициент
/255./ Зуурамтгай чанар хамгийн багатай хандлагчийг сонгоно уу
A. Этилийн спирт
B. Нэрмэл ус
C. Глицерин
D. Нүүрстөрөгчийн диоксид
E. Наранцэцгийн тос
/256./ 100 мл шингэн хандыг 1:1 концентрацтайгаар Босины реперколяцын аргаар бэлтгэхэд шаардагдах 30% этанолын хэмжээг олно уу (К=2)
A. 400 мл
B. 300 мл
C. 350 мл
D. 250 мл
E. 450 мл
/257./ Ризиноидын аргаар ургамлаас эфирийн тосыг ялгах үед ямар хандлагчийг хэрэглэх вэ?
A. Этанол
B. Нэрмэл ус
C. Ургамлын тос
D. Цэцгийн тос
E. Парафин
/258./ Перколяцийн аргаар хандлалтыг явуулахдаа түүхий эдийг норгоход хэдий хэмжээний хандлагч хэрэглэх вэ?
A. Түүхий эдээс 1 дахин их
B. Түүхий эдээс 2 дахин их
C. Түүхий эдийн хагастай тэнцэх
D. түүхий эдийн 1/3-тай тэнцүү
E. түүхий эдийн 1/4-тай тэнцүү
/259./ Аль түүхий эдийг хандлахад 0.25%-н аммиакийг хандлагч болгох вэ?
A. Алтган гагнуурын үндэс
B. Батрашийн навч
C. Чихэр өвсний үндэс
D. Долоогоны жимс
E. Ганганы өвс
/260./ Молекул диффузын хурд нь юунаас хамаардаггүй вэ?
A. Орчны зуурамтгай чанараас
B. Концентрацийн ялгаанаас
C. Диффузын үеийн зузааны өөрчлөлтөөс
D. Фазуудын хоорондох гадаргуугийн талбайгаас
E. Атмосферийн даралтаас
/261./ Урьдчилан тооцоолж жижиглэсэн түүхий эдийг хандлагч саванд хийж хандлагч нэмж үе үе хутган тасалгааны температурт хандлана. Энэ ямар арга вэ?
A. Мацерац
B. Перколяц
C. Ремацерац
D. Реперколяци
E. Хурдавчилсан хэсэгчилсэн мацерац
/262./ Тарилгын зориулалттай амьтны гаралтай бэлдмэлд дараах бэлдмэлүүдийн аль нь хамаарагдах вэ?
A. Адреналины гидрохлорид
B. Адиурекрин
C. Аиреодин
D. Синафлан
E. Преднизолон
/263./ Туйлшралын зэрэг хамгийн ихтэй хандлагчийг заана уу.
A. Диэтилийн эфир
B. Этилийн спирт

C. Хлороформ
D. Бутанол
E. Петролейны эфир

/264./ Даврын гаралтай бэлдмэлийг заана уу
A. Тиреодин
B. Пепсин
C. Панкипсин
D. Панкреатин
E. Гумизоль

/265./ Эфирийн тос бүхий бэлдмэлийг хадгалах хамгийн дээд температурыг заана уу
A. +50 -с дээшгүй
B. +100 -с дээшгүй
C. +150 -с дээшгүй
D. +200 -с дээшгүй
E. 00 -с дээшгүй

/266./ Хандыг тунгаахад хамгийн тохиромжтой температурыг заана уу
A. +8+100
B. +10+120
C. -8-100
D. -10-120
E. +6+80

/267./ Ферментийн гаралтай бэлдмэлийг ямар аргаар ариутгах нь хамгийн зохимжтой вэ?
1. Дулааны
2. Химийн
3. Өндөр даралтын дор ариутгах
4. Мембранан шүүлтүүрээр шүүх
5. Механик арга

/268./ Чихэр өвсний өтгөн ханд 100 кг-ыг бэлтгэхэд 25% хандлагдах бодис агуулсан түүхий эд хэчнээнийг авах вэ?
1. 280 кг
2. 200 кг
3. 100 кг
4. 300 кг
5. 50 кг

/269./ Шингэн хандыг ямар шалгууруудаар стандартчилдаг вэ?
1. Үйлчлэгч бодисын хэмжээ
2. Хуурай үлдэгдэл
3. Хүнд металлын хэмжээ
4. Чийглэг
5. Зуурамтгай чанар

/270./ Шинэ галены алкалойд агуулсан бэлдмэлүүдэд аль нь хамаарагдах вэ?
1. Аймалин
2. Лобесил
3. Эргометрин
4. Коргликон
5. Диоспонин

/271./ Хуурай ханд гаргаж авах технологийн схемд аль нь хамаарагдах вэ?
1. Хатаах ба хуурай ханд гаргаж авах
2. Стандартчилах
3. Ялгамлыг цэвэрлэх
4. Савлаж, хадгалах
5. Ялгамал гаргаж авах

/272./ Хандлах процессийн үед ямар үзэгдэлүүд явагдах вэ?
1. Диффузи
2. Уусах
3. Десорбц
4. Диализ
5. Талсжих

/273./ Мацерацыг ямар аргуудаар эрчимжүүлдэг вэ?
1. Түүхий эдийг урьдчилж норгох
2. Экстрагентыг хэсэгчилж хуваах

3. Хандлах хугацааг уртасгах
4. Экстрагентыг буцааж хандлалтанд оруулах
5. Түүхий эд, экстрагентын харьцааг өөрчлөх

/274./ Биомассаас эх уусмал болон жижиг хэсгүүдийг ямар аргаар салгадаг вэ?

1. Хроматографийн
2. Шүүх
3. Талсжуулах
4. Хурилтуурдах
5. Нэрэх

/275./ Өтгөн ханд бэлтгэхэд ялгамлыг ямар аргаар гарган авдаг вэ?

1. Эсрэг урсгалаар хандлах
2. Циркуляц
3. Перколяц
4. Хэсэгчилсэн мацерац
5. Идээшүүлэх

/276./ Бамбайн хандмал 120 л-ийг гарган авахад түүхий эд, экстрагент хичнээнийг авах ёстой вэ /К=1.5/?

1. 12 кг үндэс, 138 л экстрагент
2. 60 кг үндэс, 210 л экстрагент
3. 120 кг үндэс, 300 л экстрагент
4. 24 кг үндэс, 156 л экстрагент
5. 6 кг үндэс, 129 л экстрагент

/277./ Түүхий эдийг хувааж хэд хэдэн перколяторт хийж хандлах аргад дараах аргуудаас аль хамаарагдах вэ?

1. Мацерац
2. Ремацерац
3. Перколяц
4. Реперполяци
5. Эсрэг урсгалаар хандлах

/278./ Тосон хандны үйлдвэрлэлд ашиглаж болох хандлагчийг заана уу

1. Ургамлын тос
2. Метиленхлорид
3. Этанол
4. Минералын тос
5. Органик уусгагч

/279./ Амьтны гаралтай бэлдмэлийг гарган авахад хэрэглэгддэг түүхий эдийг ямар аргуудаар даршилдаг вэ?

1. Ацетоноор боловсруулах
2. Спиртээр боловсруулах
3. Сублимацын аргаар боловсруулах
4. -30-40˚С-д хөлдөөх
5. 0-8˚С-д хадгалах

/280./ Хандлах процесст нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү.

1. Түүхий эдийн технологийн шинж чанар
2. Температурын нөлөө
3. Хандлах хугацаа
4. Хандлагч шингэний шинж чанар
5. Хандлагч шингэнийг сонгон авах

/281./ Эфирийн тосны шингээх чадварт үндэслэн ургамлаас ялгах аргыг заана уу.

1. Шахах арга
2. Усны ууртай нэрэх арга
3. Хандлах арга
4. Анфлеражийн арга
5. Динамик адсорбцын арга

/282./ 96. Хандлагч шингэн өтгөн консистенцитэй байх нь хандлалтанд сайнаар нөлөөлнө. Учир нь өтгөн консистенцитэй хандлагч шингэн түүхий эдэд нэвчин орохдоо сайн байдаг.

/283./ Ургамлын түүхий эдийг хандлахын өмнө жижиглэх шаардлагатай. Учир нь гадаргуугийн талбай ихэссэнээр хандлагчтай хүрэлцэх талбай нэмэгдэнэ.

/284./ Дэвтээсэн түүхий эдийг перколяторт хийхдээ чигжилтийг тохируулах нь чухал. Учир нь чигжилт сийрэг байвал экстрагент түүхий эдэд нэвтрэн ороход сайнаар нөлөөлнө.

/285./ Бичил биетний өсгөвөрөөс гарган авсан ферментийг эмнэлгийн практикт өргөн хэрэглэнэ. Учир нь эдгээр нь олдоц сайтай, үйлдвэрлэл нь эдийн засгийн хувьд ашигтай.

/286./ Мацерацийн аргыг хуйлруулж хандлах замаар эрчимжүүлж болно. Учир нь кавитацийн үзэгдэл хандлалтыг түргэсгэнэ.

/287./ Амны хөндий, шулуун гэдсээр эмийг хэрэглэхэд шимэгдэх процессын онцлог юу вэ?
A. Эмийн бодис эхлээд элгээр дамжин тэнд байдаг ферментийн нөлөөгөөр метаболизмд ордог
B. Эмийн бодис хялгасан судсаар шимэгдэж шууд цусны бага эргэлтэнд ордог
C. Эмийн бодис хялгасан судсаар шимэгдэж шууд цусны их эргэлтэнд ордог
D. Эмийн бодис эхлээд элгэнд очоод тэндээсээ цусны ерөнхий урсгалд ордог
E. Эмийн бодис шимэгдэхгүй

/288./ Тусгайлсан заалтгүй бол шахмалын уусалтыг тодорхойлоход эргэх сагсны хурд хэд байх ёстой вэ?
A. 25 эрг/мин
B. 50 эрг/мин
C. 75 эрг/мин
D. 100 эрг/мин
E. 125 эрг/мин

/289./ Арьсаар хэрэглэдэг эмийг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?
A. Зөвхөн хэсэг газрын нөлөө үзүүлэх зорилгоор хэрэглэнэ
B. Зөвхөн ерөнхий системийн үр нөлөө үзүүлэх зорилгоор хэрэглэнэ
C. Зөвхөн хэсэг газрын нөлөө үзүүлэхээс гадна ерөнхий системийн үр нөлөө үзүүлэх зорилгоор хэрэглэнэ
D. Ерөнхий системийн үр нөлөө үзүүлэхгүйн тулд хэрэглэнэ
E. Зөвхөн арьсны элдэв өвчин эмгэгийг эмчлэх зорилгоор хэрэглэнэ

/290./ Дараах шалгуур үзүүлэлтээс шахмал эмийн биошингэцийг тодорхойлж чадах гол үзүүлэлтийг заана уу
A. Үйлчлэгч бодисын хэмжээ
B. Задралт
C. Бат бэх чанар
D. Жингийн хэлбэлзэл
E. Уусалт

/291./ Биофармаци юуг судлах вэ?
A. Эмийн бодисын биологийн үйлдэл эм зүйн хүчин зүйлүүдээс хэрхэн хамаардагийг
B. Эмийн бодисын биологийн үйлдэл эмийн хэлбэрийн төрлөөс хэрхэн хамаардагийг
C. Эмийн бодисын биологийн үйлдэл туслах бодисын шинж чанараас хэрхэн хамаардагийг
D. Эмийн бодисын биологийн үйлдэл эмийг бэлтгэх технолоийн процессоос хэрхэн хамаардагийг
E. Эмийн бодисын биологийн үйлдэл эмийн түүхий эдийн чанараас хэрхэн хамаардагийг

/292./ Индуктор бодисд ямар бодисууд хамаарах вэ?
A. Метаболизмын процессыг хурдасгадаг
B. Метаболизмын процессыг бууруулдаг
C. Шимэгдэлтийг хурдасгадаг
D. Шимэгдэлтийг бууруулдаг
E. Ялгаралтыг хурдасгадаг

/293./ Эмийн бодисыг тогтмол хурдтайгаар чөлөөлдөг шахмалаас эмийн хэлбэрээр хэрэглэх эмийн бодисууд ямар шинжийг агуулсан байх вэ?
A. Эмийн бодисын хагас задралын хугацаа 8 цагаас бага
B. Хоногийн тун 500 мг-с их
C. Эмчилгээний индекс багатай
D. Усанд муу уусдаг
E. Дотуур ууж хэрэглэхэд муу шимэгддэг

/294./ Ихэнх эмийн бодис ходоод гэдэсний замын аль хэсэгт шимэгддэг вэ?
A. Ходоодонд
B. Нарийн гэдэсний эхлэл хэсэг
C. Нарийн гэдэсний төгсгөл хэсэгт
D. 12 хуруу гэдсэнд
E. Бүдүүн гэдсэнд

/295./ Жижиглэлтийн хэмжээг багасгахад ямар эмийн шимэгдэлтэнд сөрөг нөлөө үзүүлэх вэ?
A. Фурантоин
B. Верошпирон
C. Эритромицин
D. Сульфоксазол
E. Гризеофульвин
/296./ Уусах хурд гэж юу вэ?
A. Эмийн хэлбэр шингэн орчинд бүрэн бүтэн байдлаа алдах хугацаа
B. Эмийн хэлбэрээс эмийн бодис шингэн орчинд шилжих хугацаа ба концентрацийн хоорондын хамаарал
C. Эмийн бодис шимэгдэх хэсэгт диффузлэгдэж очих хугацаа
D. Эмийн бодисын цус, лимфийн системд орох хугацаа ба концентрацийн хамаарал
E. Эмийн хэлбэр шингэн дисперсийн систем үүсгэх хугацаа
/297./ Эмийн полиморф дүрс хувиралууд хоорондоо ялгагдах шинжийг заана уу
1. Уусах чадвар
2. Хайлах температур
3. Гадаргуугийн шинж чанар
4. Исэлдэх чадвар
5. Найрлага
/298./ Диффузлэгдэх бодисын хэмжээтэй шууд хамааралтай үзүүлэлтийг заах
1. Фазыг зааглагч гадаргуу
2. Диффуззийн коффициент
3. Концентрацийн ялгаа
4. Диффузи явагдах хугацаа
5. Диффузи явагдах үеийн зузаан
/299./ Ямар эмийн хэлбэрийн хувьд уусалт тодорхойлох шаардлагатай вэ?
1. Лаа
2. Шахмал
3. Капсул
4. Мөхлөг
5. Шуугидаг шахмал
/300./ Эмийг бэлтгэх технологийн ажиллагаа түүний эмчилгээний үйлдэлд нөлөө үзүүлэх үү?
1. Эмийг бэлтгэх бүх л технологийн ажиллагаа шинжлэх ухааны үндэстэй явагдах ёстой
2. Эмийг бэлтгэх технологийн ажиллагаа эмийн бодис бие махбодид аль болох тохиромжтой нөхцөлд чөлөөлөгдөж дээд зэргийн үр нөлөө үзүүлэхэд чиглэгдэх ёстой
3. Эмийг бэлтгэх технологи нь түүний эмчилгээний үр нөлөөг өөрчлөхгүй байх ёстой бөгөөд шимэгдэлтийг сайжруулах ёстой
4. Эмийг бэлтгэх технологийн үйл ажиллагаа түүний эмчилгээний үйлдэлд нөлөө үзүүлдэггүй
5. Эмийг бэлтгэх технологи нь түүний шимэгдэлтийг сайжруулах ба эмчилгээний үр нөлөөг өөрчилдөггүй
/301./ Тетрациклины бүлгийн антибиотикийн шимэгдэлтийг ямар хүнсний бүтээгдэхүүн багасгах вэ?
1. Тараг
2. Мах
3. Талх
4. Өндөг
5. Цөцгийн тос
/302./ Ходоод гэдэсний замд эмийн бодис шимэгдэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд юу вэ?
1. Эм зүйн хүчин зүйлүүд
2. Хоол хүнсний зүйл, тэдгээрийг боловсруулах замын бүрэлдэхүүн хэсэг
3. Эмийг даруулж уухад хэрэглэх шингэний хэмжээ
4. Нас хүйс
5. Өдрийн дэглэм
/303./ Хагас задралын үед нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү
1. Эмийн бодисын тун
2. Шээсний pH
3. Өөр эм хослуулж хэрэглэсэн байдал
4. Өвчтөний нас
5. Өвчний шинж тэмдэг
/304./ Ямар эмийг жижиглэхэд эмчилгээний үйлдэл нь нэмэгдэх вэ?
1. Альдактон
2. Гризеофульвин

3. Ацетилсалицилийн хүчил
4. Эритромицин
5. Пенициллин G

/305./ Метаболизмын 1-р үед ямар процесс явагдах вэ?

1. Амин бүлэг үүсэх
2. Карбоксил бүлэг үүсэх
3. Гидроксил бүлэг үүсэх
4. Глюкуроны хүчилтэй нэгдэх
5. Хүхрийн хүчилтэй нэгдэх

/306./ Эмийн фармакокинетик гэдэг ойлголтонд аль нь хамрагдах вэ?

1. Эмийн бодисын шимэгдэх
2. Эмийн бодисын тархалт
3. Биотрансформацид орох
4. Ялгарах процесс
5. Эмийн бодисыг бэлтгэх процесс

/307./ Капсултай эмийн уусалтыг тодорхойлох шаардлагагүй. Учир нь шахах замаар гаргаж авдаггүй учир амархан задрана

/308./ Хүчиллэг шинж чанартай бодисууд ходоодонд шимэгдэнэ. Учир нь ходооодны хүчиллэг орчинд хүчиллэг бодисууд ионжино.

/309./ Адил тунтай эмийн бодис агуулсан бүх эмийн хэлбэрийн эмчилгээний үйлдэл адил байна. Учир нь эмчилгээний үйлдэл зөвхөн үйлчлэгч бодписын тунгаас хамаарна.

/310./ Дараах витаминуудаас алифатик эгнээний витаминыг сонгоно уу.

A. токоферол
B. кальцийн пангамат
C. эргокальциферол
D. ретинол
E. Рибофлавин

/311./ 10%-ийн 200 г кальцийн хлоридын уусмал бэлтгэхэд 40%-ийн /d=1.15г/см3/ уусмалаас нь хэдэн мл авах вэ?

A. 43,48
B. 52,26
C. 54,45
D. 60,26
E. 80,55

/312./ Фурациллины /E=499.7/ уусмалаас 2мл авч 10мл хүртэл сулруулаад 227нм-т спектрофотометрдэхэд D`=0.345 байсан бол процентийн конц-г тодорхойл

A. 0.00036
B. 0.0034
C. 0.00144
D. . 0.0072
E. 0.00034

/313./ ГФХ-ын дагуу Борын хүчлийн тооны тодорхойлолтыг ямар аргаар хийх вэ?

A. Алкалиметр (саармагжуулсан спиртийн оролцоотой)
B. алкалиметр (саармагжуулсан глицериний оролцоотой)
C. Саармагжуулах
D. спектрофотометр
E. перманганатометр

/314./ Салицилийн хүчлийг танихад концентрацитай хүхрийн хүчлийг юутай хамт нэмэхэд метиленбиссалицилатын улаан өнгө үүсэх вэ?

A. альдегид
B. формальдегид
C. Фенол
D. давсны хүчил
E. Натрийн нитрит

/315./ Пиразолон-5 уламжлалын эмийн уусмал руу мөнгөний нитрат нэмэхэд эхлээд хөх ягаан өнгө үүсч, дараа нь саарал өнгийн тунадас буусан бол энэ нь ямар эм байсан бэ?

A. анальгин

B. антипирин
C. Амидопирин
D. Бутадион
E. Фенилбутазон

/316./ Амфотер шинж чанартай эмийг нэрлэнэ үү?
A. Стрептомицины сульфат
B. Бензилпенициллиний натрийн давс
C. Феноксиметилпенициллин
D. Цефалексин
E. Тетрациклины гидрохлорид

/317./ Дараах эмүүдээс аль нь бүтэцдээ 10 молекул талст ус агуулдаг вэ?
A. Цайрын сульфат
B. Төмөр аммонийн квасц
C. Магнийн сульфат
D. Натрийн тетраборат
E. Кобальтын хлорид

/318./ Эуфиллины усанд уусах чанар нь дараах ямар нөхцлөөс өөрчлөгддөг вэ?
A. Агаарын нүүрсхүчлээс
B. Гэрлээс
C. Агаарын хүчилтөрөгчөөс
D. Агаарын азотоос
E. Агаарын хүхрээс

/319./ Тодорхойлж буй бодисын –метокси бүлгийг бромын усаар исэлдүүлж аммиак нэмэхэд ногоон өнгөтэй о-хиноид бүтэц бүхий нэгдэл үүсэв. Энэ сорилын нэрийг сонгоно уу?
A. Мурексид
B. Нингидрин
C. Таллейохин
D. Витали-Морены
E. Марки

/320./ Натрийн карбонатын уусмалыг натрийн гидрокарбонатын уусмалаас хэрхэн ялгах вэ?
A. лакмусын индикатораар
B. фенолфталейны индикатораар
C. метил улааны индикатораар
D. цууны хүчилтэй явагдах урвалаар
E. эрдэс хүчилтэй явагдах урвалаар

/321./ Натрийн хлоридыг Фаянсын аргаар тодорхойлоход хэрэглэдэг индикаторыг сонгоно уу.
A. калийн хромат
B. бромфенол хөх
C. натрийн эозинат
D. төмөр аммонийн цөр
E. метил улаан

/322./ Алкалоидын уусмал дээр 2-3 дусал бромын ус, 1 мл аммонийн гидроксид нэмэхэд ногоон өнгө үүсэв. Энэ ямар бүлгийн алкалоид вэ?
A. Опиин бүлгийн
B. Изохинолины бүлгийн
C. Хинолины бүлгийн
D. бензилизохинолины бүлгийн
E. Фенантренизохинолины бүлгийн

/323./ Глюкозийн тооны тодорхойлолтыг ямар аргаар хийвэл оновчтой вэ?
A. Кьелдалийн
B. гравиметрийн
C. фотометрийн
D. йодометрийн
E. аргентометрийн

/324./ Азотын хүчлийн 10%-н 900гр уусмал бэлтгэхийн тулд 5%-н 200гр азотын хүчлийн уусмал руу 50%-н 1.0543 г/см3 нягттай азотын хүчлийн уусмалаас хэдэн мл-г нэмж хийх вэ?
A. 143,55
B. 151,75
C. 160,21
D. 165,76
E. 170,62

/325./ Барбитуратуудыг хоорондоос нь ялган таних урвалжуудыг заана уу?
A. Кобальтийн нитрат
B. Мөнгөний нитрат
C. Зэсийн сульфат
D. FeCl3
E. Давсны хүчил

/326./ Өгөгдсөн химийн нэр ямар эмнийх вэ?  1,2 дифенил-4-бутил пиразолидиндион-3,5
A. Антипирин
B. Амидопирин
C. Бутадион
D. анальгин
E. Пиразолын уламжлалын бэлдмэл

/327./ Үл мэдэгдэх органик бус эмийн уусмал руу мөнгөний нитрат нэмэхэд цагаан тунадас үүсч, уг тунадас аммиакийн уусмалд бүрэн уусав.Ямар анион байсан бэ?
A. бромид
B. хлорид
C. гидробромид
D. йодид
E. натрийн йодид

/328./ Диазоны давстай азобудаг үүсгэх алкалоидыг нэрлэнэ үү?
A. Кодеин
B. Морфин
C. Этилморфин
D. Метилформин
E. Промедол

/329./ Цериметрийн аргаар тодорхойлж болох эмийг нэрлэнэ үү?
A. Бутамид
B. Дихлотиазид
C. Сульфометоксин
D. Салазопиридазин
E. Стрептоцид

/330./ Дараах витаминуудын  аль нь  тосонд уусдаг алицикл бүтэцтэй  болохыг заана уу
A. Пантотенийн хүчил
B. Ретинол ацетат
C. Токоферол ацетат
D. Викасол
E. Фолийн хүчил

/331./ Ямар эмийн усан уусмал руу натрийн ацетатын уусмал нэмэхэд тунадас үүсэх вэ?
A. Хинины дигидрохлорид
B. Хлорохины фосфат
C. Папаверины гидрохлорид
D. Кодейны фосфат
E. Атропины сульфат

/332./ Хүхрийн хүчлийн 0.25 нормаль уусмалын моль концентрац нь хэд  байх вэ?
A. 0,5
B. 0,25
C. 0,125
D. 0,1
E. 0,05

/333./ Барбитурын хүчлийн уламжлалын бүтцийн үндэс нь ямар гетероцагираг вэ?
A. Барбитурын хүчлийн давс
B. Урацилын уламжлал
C. Пиримидин
D. Ангит цагирагт
E. 6 гишүүнт ангит цагирагт

/334./ Бензилпенициллиний калийн давс усан уусмалдаа дараах бодисуудын алинтай нь үл нийцэх вэ ?
A. Прокаин
B. Пенициллиназа
C. Натрийн хлорид
D. аскорбины хүчил

E. Натрийн гидрокарбонат

/335./ Хромотропийн хүчилтэй концентрацтай хүхрийн хүчлийн орчинд аль эм нь өнгөтэй нэгдэл үүсгэх вэ?

A. Фуросемид
B. Бутамед
C. Стрептоцид
D. Пантоцид
E. Дихлортиазид

/336./ Дор өгөгдсөн химийн нэр ямар антибиотикийнх болохыг заах.
4-диметиламино- 1, 4, 4a, 5, 5a, 6, 11, 12a-октагидро- 3, 5, 6, 10, 12, 12a гексаокси-6-метил-1, 11-дикетонафтацен-2
карбоксиамидын гидрохлорид

A. хлорамфеникол
B. тетрациклины гидрохлорид
C. окситетрациклины гидрохлорид
D. хлортетрациклины гидрохлорид
E. хлоромицетин

/337./ Ус төрөгчийн хэт исэл, натрийн нитрит, төмрийн (II) сульфат, ангижруулсан төмрийн тооны тодорхойлолтын алинд нь ч хэрэглэж болох аргыг сонгоно уу.

A. ацидиметр
B. алкалиметр
C. комплексонометр
D. рефрактометр
E. перманганатометр

/338./ Дор өгөгдсөн химийн нэр ямар антибиотикийнх болохыг заах. 4-диметиламино-1, 4, 4a, 5, 5a, 6, 11, 12a-октагидро- 3, 6, 10, 12, 12a пентаокси-6-метил-1, 11-дикетонафтацен-2 карбоксиамидын гидрохлорид

A. хлорамфеникол
B. тетрациклины гидрохлорид
C. окситетрациклины гидрохлорид
D. хлортетрациклин
E. хлормицетин

/339./ Натрийн метабисульфитийг дараах тарилгын уусмалуудын алинд тогтворжуулагч болгон нэмдэг вэ?

A. Глюкоз
B. Аскорбины хүчил
C. Адреналины гидрохлорид
D. Морфины гидрохлорид
E. Прокаины гидрохлорид

/340./ Кальцийн хлоридыг усанд уусгаж хром хар хөх индикатор нэмээд Трилон Б-гээр титрлэхэд урвал явагдаагүй. Юу нэмэх ёстой байсан вэ?

A. давсны хүчил
B. цууны хүчил
C. Аммиакийн буфер
D. ацетатын буфер
E. азотын хүчил

/341./ Этилийн спиртийг фотометрийн аргаар тодорхойлох нь

A. Этилийн спирт $K_2Cr_2O_7$—г исэлдүүлэх
B. Этилийн спирт $K_2Cr_2O_7$—г ангижруулах
C. Этилийн спирт $K_2Cr_2O_7$—тай урвалд орохгүй байх
D. $K_2Cr_2O_7$ нь этилийн спиртийг исэлдүүлэх
E. $K_2Cr_2O_7$ нь этилийн спиртийг ангижруулах

/342./ Барбитуратуудын натрийн давсанд тооны тодорхойлолтоор хийхэд аль аргыг ашиглах вэ?

A. Усан биш орчинд алкалиметри
B. Усан орчинд алкалиметри
C. Усан, спиртын орчинд ацидиметри
D. Усан орчинд ацидиметри
E. Алкали болон ацидиметри

/343./ Эмийн бэлдмэлийг усанд уусган, 1 мл мөнгөний нитратын аммиакийн уусмал нэмэхэд шаравтар өнгийн тунадас үүсч, халаахад бараан өнгөнд шилжин, хуруун шилний хананд” мөнгөн толь” үүсэв. Энэ ямар бэлдмэл байсан бэ?

A. Амидопирин
B. Антипирин
C. Изониазид
D. кордиамин
E. Никотинамид

/344./ Парацетамолын тооны тодорхойлолтыг хийхэд ямар уусгагч хэрэглэх вэ?
A. натрийн хлорид
B. натрийн шүлт
C. нэрмэл ус
D. давсны хүчил
E. калийн бромид

/345./ Концентрацитай хүхрийн хүчлийг дараах бэлдмэлүүдийн алийг танихад хэрэглэх вэ?
A. Азот агуулсан органик нэгдлүүд
B. Димедрол
C. Дифенгидрамины гидрохлорид
D. Этакридин лактат
E. Гексаметилентетрамин

/346./ Алкалоидын ерөнхий тунадасжуулах урвалжид хамаарагдах урвалжийг заана уу?
A. Витали-Морены урвалж
B. Мурексидын сорил
C. Пикриний хүчил, Драгендорфийн урвалж, Вагнерийн урвалж
D. Танин, Несслерийн урвалж, Бушардын урвалж
E. Таллейохинины сорил

/347./ Молекулдаа анхдагч үнэрт амино бүлэг агуулсан эмийн бэлдмэлийн тооны тодорхойлолтонд дараах аргуудын алиныг нь сонгон хэрэглэх вэ?
A. цериметрийн арга
B. нитритометрийн арга
C. меркуриметрийн арга
D. комплексонометрийн арга
E. тунадасжуулах арга

/348./ Тарваган шийрийн шахмалын нунтгаас 4.0055 гр-г хэмжин авч алкалоидыг нь хлорформоор хандлан ялган авч хлорформыг нь ууршуулан үлдэгдлийг нь 5мл спирт 15 мл усанд уусгаад метил улаан- метил хөхийн / 2:1/ индикатортой 0.01N давсны хүчлээр титрлэхэд 0.53 мл орсон ба шахмалын дундаж жин нь 0.30329 бол нийлбэр алкалойдыг граммаар ол /T=0.00244/
A. 0.000095
B. 0.000090
C. 0.000098
D. 0.00011
E. 0.00013

/349./ Дараах нэгдлүүдээс фенолт хүчлийг заана уу
A. Салицилын хүчил
B. Глютамины хүчил
C. Параминобензойны хүчил
D. Бензоины хүчил
E. Сүүний хүчил

/350./ Зүрхний гликозидын эмийн хэлбэрийн тооны тодорхойлолтыг ямар аргаар хийх вэ?
1. Биологийн стандартчилал
2. Химийн
3. Фотоколориметр
4. ӨИШХ
5. ХЯТ-ны спектрофотометр

/351./ Аль эмийн бодисуудыг усанд уусгахад гидролизод ордог вэ?
1. CaCl2
2. NaNO2
3. NaHCO3
4. Na2B4O7
5. NaCl

/352./ Кальцийн пангамат яагаад ус татамхай шинж чанартайг заана уу
1. Найрлагандаа азот агуулсан
2. Найрлагандаа кальци агуулсан
3. Найрлагандаа хлор агуулсан

4. Найрлагандаа кристалл ус агуулсан
5. Найрлагандаа карбоксилийн бүлэг агуулсан

/353./ Аль эмийг шүлтийн гидролизод оруулж таних вэ?
1. Калийн ацетат
2. Нитроглицерин
3. Аскорбины хүчил
4. Пирацетам
5. Кальцийн лактат

/354./ Гликозид бүтэцтэй антибиотикуудыг бичнэ үү?
1. Стрептомицин
2. Неомицин
3. Гентамицин
4. Мономицин
5. Цефазолин

/355./ Дараах нэгдлүүдээс дааварт хамаарагдах нэгдлийг заана уу.
1. Рибофлавин
2. Дигоксин
3. Кодеин
4. Тиреоидин
5. Строфантин

/356./ Нитроглицерины тооны тодорхойлолтын зөв вариантыг сонгоно уу?
1. Саванжуулах урвалыг ашиглах бөгөөд үүнд нитроглицерины нэг молекул 4 молекул натрийн шүлттэй урвалд орно. Түүний 2 нь нитроглицериныг саванжуулж, үлдсэн 2 нь урвалын үр дүнд үүссэн шоргоолжны ба цууны хүчлийг саармагжуулна.
2. Саванжуулах урвалыг ашиглан ангижруулагчийн оролцоотойгоор хийх бөгөөд үүнд 1 молекул нитроглицерин, 5 молекул натрийн шүлт урвалд орно. Түүний 3 молекул нь нитроглицеринийг саванжуулж, үлдсэн 2 молекул нь урвалын үр дүнд үүссэн шоргоолжны ба цууны хүчилтэй урвалд орно.
3. Нийлмэл эфир учир саванжуулах урвалыг ашиглан саармагжуулах аргаар хийнэ.
4. Саванжуулах урвалыг ашиглан, исэлдүүлэгчийн оролцоотойгоор хийх бөгөөд үүнд 1 молекул нитроглицерин 5 молекул натрийн шүлттэй урвалд орно. Түүний 3 молекул нь нитроглицеринийг саванжуулж, үлдсэн 2 молекул нь урвалын үр дүнд үүссэн шоргоолжны ба цууны хүчилтэй урвалд орно.
5. Нийлмэл эфир учир саванжуулах урвалыг ашиглан нитритометрийн аргаар хийнэ

/357./ Усанд үл уусдаг нэгэн витамин хэт ягаан туяанд маш мэдрэмтгий, харин халаахад /2000 С/ болон хүчил шүлтийн нөлөөнд тэсвэртэй байдаг. Энэ ямар витамин болохыг заана уу.
1. Витамин А
2. Токоферол
3. Витамин Р
4. Витамин Е
5. Витамин D

/358./ Тооны тодорхойлолтонд йодометрийн аргыг хэрэглэж болох бодисыг заана уу.
1. Витамин РР
2. Витамин С
3. Витамин А
4. Нитрофурантоин
5. Витамин Е

/359./ Ямар хэлбэрийн эфедриныг эмнэлгийн практикт хэрэглэдэг вэ?
1. Эритро-трео хэлбэр
2. L- Эритро хэлбэр
3. D- Эритро хэлбэр
4. D- Трео хэлбэр
5. L- Трео хэлбэр

/360./ Нитритометрийн аргад ямар индикаторуудыг хэрэглэдэг вэ?
1. Фенолфталеин
2. Тропеолин ОО
3. Метилийн улаан
4. Йод цардуулын цаас
5. Метилений хөх

/361./ Дигиталисын бүлгийн зүрхний гликозидуудыг бичнэ үү?
1. Дигитоксин

2. Гитоксин
3. Целанид
4. Дигоксин
5. Кордигит

/362./ Дараах нэгдлүүдээс зүрхний гликозидэд хамааргдах нэгдлийг заана уу.

1. Робинин
2. Дигоксин
3. Кодеин
4. Строфантин
5. Тиреодин

/363./ Пурины уламжлалын эмүүдээс аль нь натрийн гидроксид ба кобальтийн хлоридтай ягаавтар тунадас үүсгэх вэ?

1. Темисал
2. Теобромин
3. Кофеин
4. Теофиллин
5. Натрийн Кофеинбензоат

/364./ Витамин В1-ыг таних онцлог урвалыг заана уу.

1. Индофенол үүсгэх
2. Цианидины сорил
3. Гироксамын сорил
4. Тиохром үүсгэх
5. ХЯТ-нд ногоон флуоресценцтэй

/365./ Гексаметилтетрамидын тооны тодорхойлолт титриметрийн аргаар шууд хийхэд аль титрийн уусмалыг ашиглах вэ?

1. NaOH
2. NaNO2
3. Na2S2O3
4. HCl
5. Трилон-Б

/366./ Кортикостериодуудын альфа кетолын бүлгийг ямар урвалжуудаар таних вэ?

1. Фелингийн урвалж
2. Мөнгөний нитратын аммиакийн уусмал
3. 2,3,5-трифенилтетразолын уусмалаар
4. Гидроксиламинаар
5. Конц. HNO3

/367./ Фенолт нэгдлүүдийг гарган авах эх үүсгэвэрийг заана уу?

1. Чулуун нүүрсний давирхай
2. Зарим ургамлын эфирийн тос
3. Нийлэгжүүлэх
4. Шохой
5. Кокс

/368./ Дараах гормонуудаас эр бэлгийн гормонуудыг нэрлэ

1. Прогестерон
2. Тестостерон
3. Прегнин
4. Метилтестостерон
5. Синэстрол

/369./ Уусдаг стрептоцид ба сульфацил натрийг ялгахад аль нөхцлүүдийг ашигладаг вэ?

1. Усан уусмалын pH-аар
2. Азо будаг үүсгэх урвалаар
3. Усанд уусах чанараар
4. Гидролизод оруулж
5. Спиртэнд уусах чанараар

/370./ Броматометрийн аргаар тооны тодорхойлолт хийж болох бодисыг заана уу

1. Сульфаниламид
2. Бензойны хүчил
3. Ацетилсалицилийн хүчил
4. Салицилийн хүчил
5. Парацетамол

/371./ Өнчин тархины гормонуудыг нэрлэнэ үү?

1. Питунтрин
2. Вазопрессин
3. Окситоцин
4. Инсулин
5. Адреналин

/372./ Витамин B6-ыг таних онцлог урвалыг заана уу.

1. Тиохром үүсгэх
2. Цианидины сорил
3. Гироксамын сорил
4. Индофенол үүсгэх
5. ХЯТ-нд ногоон флуоресценцтэй

/373./ Йодын ямар бэлдмэлийг анагаах ухааны практикт хэрэглэдэг вэ?

1. 5%-ийн спиртэн уусмал
2. 10%-ийн спиртийн уусмал
3. Люголийн  уусмал
4. 5%-ийн усан уусмал
5. 10%-ийн тосон уусмал

/374./ Рибофлавин  гэрлийн нөлөөгөөр амархан задрах ба энэ нь орчны  pH-аас хамаарна.Хүчиллэг ба шүлтлэг орчинд үүсэх бодисыг заана уу.

1. Хүчиллэг орчинд шар өнгөтэй,  флуоресценци бүхий люмифлавин
2. Хүчиллэг буюу саармаг орчинд шар өнгөтэй,  флуоресценцгүй люмихром
3. Хүчиллэг буюу саармаг орчинд шар өнгөгүй люмихром
4. Шүлтлэг  орчинд шар өнгөтэй,  флуоресценци бүхий люмифлавин.
5. Аль нь ч биш

/375./ Дараах эмүүдээс ангижруулагчийг заана уу?

1. FeCl3
2. Аскорбины хүчил
3. NaCl
4. Формальдегид
5. NaBr

/376./ Нитроглицерины таних урвалыг заана уу

1. Гидролизийн үр дүнд үүсэх нитрит ионыг дифениламинаар исэлдүүлж хөх өнгө өгснөөр
2. Гидролизийн үр дүнд үүсэх нитрат ионыг дифениламинаар исэлдүүлж хөх өнгө өгснөөр
3. Гидролизийн үр дүнд үүсэх спиртийн хэсгийг калийн бисульфаттай халаахад акролеины хурц үнэр үнэртсэнээр
4. Гидролизийн үр дүнд үүсэх глицеринийг калийн гидросульфаттай халаахад акролеины хурц үнэр үнэртсэнээр
5. Гидролизийн үр дүнд үүсэх спиртийн хэсгийг калийн гидросульфиттэй халаахад акролеины  хурц үнэр үнэртсэнээр

/377./ Адреналиныг нор адреналинаас ямар урвалаар ялгах вэ?

1. Усанд уусалтаар
2. Алкалоидуудын урвалаар
3. FeCl3
4. Янз бүрийн  pH –д исэлдэх урва
5. AgNO3

/378./ Эмийн бодисуудын тогтвортой чанарт нөлөөлдөг хүчин зүйлүүдийг заана уу.

1. Гэрэл
2. Температур
3. Технологийн нөхцөл
4. Савлалт
5. Чийг

/379./ Цус орлох шингэнүүдэд калийн болон натрийн хлоридуудыг ямар аргуудаар тооны тодорхойлолт хийх вэ?

1. Аргентометрийн Гейлюсак
2. Аргентометрийн Морийн арга
3. Аргентометрийн Фаянс /натрийн эозинат/
4. Аргентометрийн Фольгард
5. Аргентометрийн Фаянс /бромфенол хөх/

/380./ Тропаны бүлгийн алкалоидын чанарын шинжилгээнд Витали-Морены сорилыг хэрэглэдэг. Энэ нь алкалоидыг гидролизд оруулсны дараа  нитрожуулж, хиноид бүтэц үүсэх шинж чанарт үндэслэнэ.

/381./ +50С-д формальдегидыг хадгалахад цагаан тунадас бууна. Учир нь формальдегид исэлдэх урвалд орно.

/382./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтворжуулахын тулд натрийн метабисульфит эсвэл натрийн сульфит нэмж өгдөг. Учир нь аскорбины хүчил нь агаар, металл, хүчил, шүлтийн нөлөөгөөр амархан исэлддэг

/383./ Метилийн спирт организмд этилийн спирттэй хамт орсон тохиолдолд
A. Метилийн спиртийн хоруу чанар ихэснэ.
B. Метилийн спиртийн хоруу чанар илрэхгүй.
C. Метилийн спиртийн хоруу чанар 50% буурна.
D. Метилийн спиртийн хоруу чанар этилийн спиртээс хамаарахгүй
E. Метилийн спиртийн хоруу чанар 10% буурна
/384./ Металл хоруудыг биоматериалаас ялган авахад ямар аргыг ашигладаг вэ?
A. Хүчилжүүлсэн усаар ялгах
B. Хүчилжүүлсэн спиртийн уусмалаас хандлах
C. Минерализацын арга
D. Усаар хандлах
E. Биоматериалд шууд тодорхойлох
/385./ Хараанд нөлөөлөх метилийн спиртийн тун аль нь вэ?
A. 10-15 г
B. 7-8 г
C. 15-20 г
D. 3-5 г
E. 0.7-0.8 г
/386./ Амьтны гаралтай материалаас хүчилжүүлсэн усаар хорт бодисуудыг ялгахдаа хүчилжүүлсэн ус ба шинжи
A. 1:2
B. 1:4
C. 1:12
D. 1:10
E. 1:5
/387./ Фенобарбиталын хордуулах тунг заана
A. 1-1.5 гр
B. 0.6-1 мг
C. 1.5-2 гр
D. 1-3 мг
E. 0.6-1 гр
/388./ Формальдегидийн метаболизмийн дүнд үүсэх нэгдлийг нэрлэнэ үү.
A. Хурган чихний хүчил
B. Цууны хүчил
C. Нүүрсхүчлийн хий
D. Метаболизмд оролгүй гадагшилна
E. Шоргоолжны хүчил
/389./ Азотын ба хүхрийн хүчлийн тусламжтай минерализаци явуулахад эрдэс хүчлүүдийг ямар харьцаагаар авдаг вэ?
A. 1:1
B. 1:2
C. 1:12
D. 2:1
E. 1:10
/390./ Бодисын гэрлийн хугарлын илтгэгчийг ямар багажаар тодорхойлдог вэ?
A. Поляриметр
B. Гемометр
C. Рефрактометр
D. Оксигемометр
E. Фотометр
**/391./ Зүрхний гликозидыг биоматериалаас ялгахад ямар уусгагч хэрэглэдэг вэ?**
A. Метилийн спирт
B. Хлороформ

C. Этилийн спирт
D. Диэтилийн эфир
E. Нэрмэл ус

/392./ Конгийн цаас хөх болох нь биоматериалд ямар бодис байгааг илэрхийлэх вэ?
A. Биоматериалын хүчиллэг исэлдлийн бүтээгдэхүүн
B. Гадны хүчил
C. Гадны шүлт
D. Биоматериалд шүлтлэг исэлдлийн бүтээгдэхүүн
E. Гадны хүчил, шүлт

/393./ Атропины тунг хэтрүүлэн хэрэглэсний улмаас бие махбодид үүсэх шинж тэмдэгийг нэрлэнэ үү.
1. Хий юм харах
2. Хөдөлгөөн ихсэх
3. Чанга ярих
4. Хамар, ам хатах
5. Хүүхэн хараа нарийсах

/394./ 1 мл шинжилж буй уусмал дээр 1 мл 1% шинэхэн бэлтгэсэн резорцины шүлтлэг уусмал нэмж халаахад ягаан өнгө үүссэн бол уг дээжинд ямар хорт бодис агуулагдаж байна вэ?
1. Хлороформ
2. Хлоралгидрат
3. 4 хлорт нүүрстөрөгч
4. Формальдегид
5. Синилийн хүчил

/395./ Хар тугалгаар хордсон үед ямар эд эрхтнийг гэмтээдэг вэ?
1. Хараанд өөрчлөлт орно
2. Цус, судсанд өөрчлөлт орно
3. Шүдийг гэмтээнэ.
4. Мэдрэлийн эдэд өөрчлөлт орно
5. Үс хугарамтгай болно

/396./ Манганийн нэгдлийн бие махбодид үзүүлэх хорт нөлөөллийг заана уу?
1. ТМС-д нөлөөлнө.
2. Бөөр гэмтээнэ.
3. Уушиг гэмтээнэ
4. Элэг гэмтээнэ.
5. Ходоод гэдэсний ханыг түлнэ

/397./ Хүнд металлын давсын хордлогын үед хэрэглэх антидотыг заана уу?
1. Витамин В6 5% уусмал
2. Натрийн тиосульфатын 30% уусмал
3. Протамины сульфатын 1% уусмал
4. Унитол 5% уусмал
5. Танины уусмал

/398./ Минерализатын шүүгдсэнд ямар металл хорыг илрүүлэх вэ?
1. Мөнгө
2. Хром
3. Магни
4. Цайр
5. Кадми

/399./ Морфины хордлогын үед илрэх шинж тэмдэгийг заана уу.
1. Толгой эргэх
2. Ухаан балартах
3. Нойрмоглох
4. Коллапсид орох
5. Хөөрлийн байдалд орох

/400./ Мэс заслын оёдлын материалуудаас аль нь дотуур оёдолд хэрэглэгддэг вэ / эдэд шимэгддэг
A. Шелк хирургический
B. Нитки капроновые
C. Кетгут
D. Нитки льняные
E. Волос конский

/401./ Давсагыг дурандахад болон  давсганд эмчилгээ хийхэд дараах багажны алиныг хэрэглэх вэ?
A. Ректоскопи
B. Троакаскопи

C. Уретроскопи
D. Цистоскопи
E. Гастроскопи

/402./ Цусан дахь дүрст элементийн тоог дараах багажуудын алиныг нь хэрэглэж тогтоох вэ
A. Гемометр
B. Гемоцитометр
C. Колориметр
D. Оксигемометр
E. Аппарат Панченков

/403./ Мэдрэлийн мэс ажилбарын багажийг сонгон заана уу?
A. Пульпэкстрактор
B. Экскаватор
C. Элеваторы
D. Коловорот массивный
E. Распатор

/404./ Дараах багажны аль нь ерөнхий мэс ажилбарын багажинд хамаарагдахгүй вэ?
A. Скальпели
B. Ножи хирургические
C. Элеваторы
D. Долото
E. Пила рамочная

/405./ Дараах багажуудаас мэдрэлийн эмчийн хэрэглэлийг сонго.
1. Канюли для проколо желудочков мозга
2. Молоток неврологический
3. Коловорот массивный
4. Щипцы Егорова-Фрейдина
5. Зажим кровоостанавливающий нейрохирургический

/406./ Склеренхим эд ямар эсээс тогтох вэ?
A. паренхим
B. прозенхим
C. колленхим
D. аэронхим
E. хлоренхим

/407./ Прокамбийн эсүүд ямар хэлбэртэй вэ?
A. хурц үзүүртэй паренхим
B. Хавтгай прозенхим
C. хурц үзүүртэй прозенхим
D. эс хоорондын зайтай паренхим
E. зууван паренхим

/408./ Сүүн цоргонд агуулагдах шингэнийг юу гэж нэрлэдэг вэ?
A. гиалоплазм
B. латекс
C. стром
D. матрикс
E. нуклеоплазм

/409./ Гидатод ямар үүрэгтэй вэ ?
A. ургамалд усыг гаднаас нэвтэрүүлэх
B. усыг шингээх
C. усыг дусал хэлбэрээр гадагш ялгаруулах
D. ус ба бусад органик бодисыг нөөцлөх
E. тэжээлийн бодис хадгалах

/410./ Усны амсраар ус гадагшлах процессыг юу гэж нэрлэдэг вэ?
A. гидротаци
B. гидротропизм
C. гуттаци
D. апопласт
E. симпласт

/411./ Хоердогч бүрхүүл эдэд хамаарагдах эдийг нэрлэнэ үү.
A. феллоген
B. эпиблем
C. эпидерм

D. холтос
E. феллем
/412./ Нарсны овгийн ургамлууд ямар шинжтэй вэ?
A. навчис ногоон
B. навчис ногоон өнгөгүй
C. навчис цуулбар
D. модлог дотроо давирхайн суваг хоолойгүй
E. далд үрт ургамал
/413./ Ямар эсүүдээс илчүүт давхраа бий болох вэ?
A. феллоген
B. феллем
C. феллодерм
D. эпиблем
E. эпидерм
/414./ Хоёрдогч меристем ямар эдээс үүсч бий болох вэ?.
A. прозенхим
B. паренхим
C. колленхим
D. дерматоген
E. периблем
/415./ Меристем ямар эсээс тогтдог вэ?
A. амьд эсээс
B. үхсэн эсээс
C. үхсэн прозенхим эсээс
D. амьд паренхим эсээс
E. эс хоорондын зайтай амьд паренхим эсээс
/416./ Ургамлын хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ямар үйл ажиллагаа явуулахыг хориглодог вэ?
1. хорио цээртэй нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх
2. Ургамлын гаралтай бүтээгдхүүнийг зөвшөөрөлгүй тээвэрлэх
3. хөнөөлийн голомтот байрыг зөвшөөрөл авалгүй ашиглах
4. ургамлын түүхий эдийг оруулах, дамжин өнгөрүүлэх
5. халдвартай үр суулгацыг тариалах
/417./ Колленхим эсийн хана ямар найрлагатай вэ ?
1. целлюлоз
2. ус
3. пектин
4. уураг
5. гемицеллюлоз
/418./ Дамжуулах эд флоэмийн бүрэлдэхүүнд дараах элементүүдээс аль нь хамааргдах вэ?
1. долонгийн паренхим
2. шигшүүрт хоолой
3. дагуул эс
4. ялгаруулах эс
5. модлогийн паренхим
/419./ Рибосомын бүрэлдэхүүнийг хэлнэ үү.
1. полисахарид
2. уураг
3. нуклейн хүчил
4. - рнк
5. днк
/420./ Электрон микроскопт харагдах органоидыг нэрлэ.
1. нуклеоплазм
2. гольджийн аппарат
3. лизосом
4. пластид
5. пластид бөөм
/421./ ЭУТЭ-ийн чанарын тодорхойлолтод юу хамаарах вэ?
A. Тоон үзүүлэлтүүд
B. Хадгалах хугацаа
C. ЭУТЭ-ийг бэлтгэх хугацаа
D. Фармакологийн үндсэн үйлдэл

E. Түүхий эдийн чанарын сорилтууд
/422./ Дараах нүүрс-устөрөгчдийн аль нь олигосахаридад хамаарагдах вэ.
A. Биоз
B. Мальтоз
C. Триоз
D. Фруктоз
E. Глюкоз
/423./ Протейдууд юунаас тогтох вэ.
A. b -аминхүчил
B. ус
C. ионууд
D. липид
E. a- аминохүчил
/424./ Долоогоны бэлдмэл ямар нийлмэл эмийн найрлагад ордог вэ?
A. Кардиовален
B. Кордиамин
C. Корвалол
D. Кордафен
E. Кордарон
/425./ Ургамлын эд эсэд липидүүд дараахь үүрэгтэй
A. Энерги, дулааны эх үүсвэр болох
B. Эд эсийг гадны таагүй нөлөөнөөс хамгаалах
C. Эд эсийн бодисын солилцоог зохицуулах
D. Тулгуур эдийн үүрэг гүйцэтгэх
E. Исэлдэн ангижрах урвалыг түргэсгэх
/426./ ЭУТЭ-дэх эфирийн тосны тооны тодорхойлолтыг хэрхэн явуулдаг вэ?
A. Усныууртай нэрэх замаар
B. Энгийн нэрэх аргаар
C. Жин, эзэлхүүний аргаар
D. Чанарын урвалаар
E. Поляриметрээр
/427./ Эмийн ургамлыг хэдэн хувийн чийглэгтэй болтол нь хатаах ёстой вэ.
A. 10%
B. 15%
C. 12%
D. 5-10%
E. 10-12%
/428./ Дараахь түүхий эдүүдийн аль нь алкалоид агуулдаг вэ.
A. Марцны хоржигнуур
B. Алтанцэгцүүхэй
C. Гурван цэцэгт нил
D. Ээрэм шарилж
E. Алтан товч
/429./ Пиримидиний ба пурины сууриуд юугаар ялгаатай вэ.
A. эрдэс хүчил
B. аминхүчлийн дараалаар
C. аминхүчлийн төрлөөр
D. амин хүчлийн тоогоор
E. физик шинж чанараар
/430./ Хоёр бүрэлдэхүүнт ферментүүд нь юунаас тогтох вэ.
A. Сахар
B. Нүүрс-ус
C. Кофермент
D. Микроэлемент
E. Энзим
/431./ Шувуун тарнаас ямар биологийн идэвхт бодисийг цэвэршүүлэн ялган авдаг вэ?
1. Мочевин
2. Кверцетин
3. Рутин
4. Авикулярин
5. Апигенин

/432./ Эфирийн  тос усны уууртай хамт нэрэгдэх чанартай. Ийм учраас ФК-н 1-р аргаар буюу усны уууртай хамт нэрэх аргаар түүхий эдээс ялган авдаг.

/433./ Алкалоид нь суурилаг шинж чанартай. Учир нь гидроксилийн бүлэг агуулсан байна.

/434./ Хорхойг хөөх ба туулгах эмийг хэдүй үед уулгах хэрэгтэй вэ?. зөв хариултыг сонгоно уу.
A. Хоолны дараа
B. Өлөн дээр нь
C. Хоолны өмнө
D. Унтахын өмнө
E. Хоолтой хавсарган

/435./ Уламжлалт анагаах ухааны онолоор зүрх нь таван махбодын аль махбодод хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу.
A. Гал
B. Ус
C. Огторгуй
D. Шороо
E. Хий

/436./ Уушигны цэцэг эрхтэн аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу.
A. Хэл
B. Нүд
C. Чих
D. Уруул
E. Хамар

/437./ Язгуурын шар буюу тус бүрийн шараас шингээгч шар нь ямар эрхтэнд оршдог вэ?
A. Элгэнд
B. Ходоодонд
C. Гэдсэнд
D. Зүрхэнд
E. Арьсанд

/438./ " Анагаах ухааны 4 үндэс " – ийн Хойд үндэс хэмээх бүлэгт хүрэлцэх судлаар өвчнийг танин барихын бүлэгт  төмөр махбод ямар улиралд дэлгэрэнэ гэж үздэг вэ? Зөв хариултыг сонгоо уу.
A. Зун
B. Өвөл
C. Улирал бүрийн завсар
D. Намар
E. Хавар

/439./ Сарнисныг хураах, муу цусыг ялгах, хорыг тайлах, хөлөргөх, шээлгэхээр хэрэглэхэд мэдэгдэм үйлдэлтэй эмийг юу гэх вэ?.
A. талх
B. үрэл
C. зуурмал
D.  ханд
E. тан

/440./ Ямар зүйлийн эмийг хаврын сүүл зуны эхэнд түүвэл нэн сайн бэ ? зөв хариултыг сонгоно уу.
A. Жимсний зүйл
B. Модны зүйл
C. Цэцгийн зүйл
D. Үндэсний зүйл
E. Навчны зүйл

/441./ Гара хэмээх эмийн түүхий эд ямар өвчнийг анагаах эмийн бүлэгт хамаарах вэ ? зөв хариултыг сонгоно уу.
A. Шарыг арилгах эмийн бодис
B. Бадганыг арилгах эмийн бодис
C. Шар усны өвчнийг анагаах эмт бодис
D. Халууныг арилгах эмийн бодис
E. Цусны өвчнийг анагаах эмийн бодис

/442./ Яс , булчин, мах зэрэг биеийн чийрэг бүрэлдэхүүн одон зурхайн таван махбодын аль махбодоос үүсэлтэй вэ? Зөв хариултыг сонгоно уу.
A. Огторгуй

B. Шороо
C. Гал
D. Ус
E. Хий

/443./ Задь, саримас, сонгино гэх мэт эмт бодисууд ямар эрдэмтэй эмэнд багтах вэ? Зөв хариултыг сонгоно уу.

A. Бүлээний эрдэмтэй эм
B. Тослог эрдэмтэй эм
C. Хүндийн эрдэмтэй эм
D. Батлаг эрдэмтэй эм

/444./ 4- улиралын хувиралтын нөлөөнд үүсдэг 5- цулын хоорондын харьцааг хэрхэн шинжлэх вэ? Зөв хариултыг сонгоно уу.

1. Эх
2. Нөхөр
3. Дайсан
4. хөвгүүн
5. судлын лугшилтаар

/445./ Барүрийн латин нэрийг сонгоно уу.

1. Gardenia jasminoides
2. Melia toosendan
3. Terminalia arjuna
4. Terminalia belerica
5. Terminalia chebula

/446./ Бие хэл сэтгэлийн хөдөлгөөнийг тогтуун болгох, шингээлтэнд хавсрах, тамирыг шимжүүлэх, нойрсуулах, урт наслуулах, тэсвэртэй болгох, үесийг барилдуулах үйлдэлтэй ямар бадганы үйл ажиллагаа вэ?

1. Шүтүүлэгч бадгана
2. Ялзлагч бадгана
3. Хангагч бадгана
4. Ерөнхий бадгана
5. Барилдуулагч бадгана

/447./ Шар усны өвчнийг анагаах эмт бодисыг сонгоно уу.

1. Талгадорж
2. барүр
3. Мөнгөн ус
4. Шар мод
5. Шилгавар

/448./ Эртний энэтхэгийн буддистууд ертөнцийг бурхан бүтээсэн биш харин ямар нэг анхны бодисуудаас үүсэн хувирч хөгжсөний үр дүн гэж үздэг байсан. Иймээс энэтхэгийн буддистуудын анхны бодисуудыг сонгоно уу.

1. шороо
2. ус
3. гал
4. хий
5. Огторгуй

/449./ Эрдэс амьтны дун хавтасны зүйл болон чанараар хэврэг, эмт бодисыг номхотгоход тохирно. Зөв хариултыг сонгоно уу.

A. Шатаах
B. Шаргаах
C. Хайлуулах
D. Хуйхлах
E. Нурамлах

/450./ Эмт бодисоо эмт сүмс, архи, сүү, шар тос, ус мэтийн шингэн биетэд хийж буцалгахыг

A. Жигнэх
B. Хуйхлах
C. Чанах
D. Хайлуулах
E. Шаргаах

/451./ Төвдөөр Дүмдаг гэж нэрлэдэг эмийн ургамлын нэрийг сонго.

A. Хужир
B. Вүлдог

C. Хүнцэл
D. Хилэнц хорхой
E. Донрог

/452./ Сэмбэрүү-5 талхан эмийн чадлыг сонгоно уу.
A. Цайвар бор бадгана
B. Эс боловсорсон
C. Ходоод хөөх
D. Ходоодны хижиг
E. Усан хаван

/453./ Манчинг номхотгохдоо 1.5 кг арүрийг чанасан сүмс 15 литрийг хэрэглэнэ. Хэдэн кг болтол нь манчинг номхотгох вэ.
A. 10 кг
B. 12
C. 8
D. 5
E. 4

/454./ Норов-7 тангийн амт
A. Гашуун, исгэлэн, эхүүн
B. Гашуун, исгэлэн, өчүүхэн эхүүн
C. Гашуун, эхүүн, исгэлэн
D. Гашуун, эхүүн, өчүүхэн исгэлэн
E. Гашуун, эхүүн, давслаг

/455./ Сэмбэрүү-5 талхан эмэнд хөл болж ордог Гаварын хальсны төвд нэрийг сонгоно уу.
A. Шингүн
B. Шунх
C. Шинц
D. Шинца
E. Шинар

/456./ Ямаан зангууны архин эмийн чадал нь юу вэ?
1. Яс, үес
2. Шар ус
3. Бөөрний өвчин
4. Хийг дарах
5. Хий бүрэлдсэн өвчин

/457./ Мана-4 тангийн чадал
1. Хий цусны хатгалгааг дарна
2. Хий цус харшсаныг дарна
3. Хижгийн халууныг боловсруулна
4. Халууныг боловсруулна
5. Цайвар бор бадганыг дарна

/458./ Уламжлалт монгол эмийн номхотголд хэрэглэх хатуу биет туслах материалд аль түүхий эд материалууд орох вэ. Зөв хариултыг сонгоно уу.
1. Арвай
2. Элс
3. Бал
4. Хар буурцаг
5. Буудай

/459./ Үрэл эмийн төрөл зүйлийг зөв сонгон уу?
1. Балт үрэл
2. Усан үрэл
3. Агшаамал үрэл
4. Шар тост үрэл
5. Бурамтай үрэл

/460./ Цагаан тан эмийн бүрэлдэхүүнт орох эмт бодисуудыг сонго.
1. Арүр
2. Лидэр
3. Барүр
4. Гандигар
5. Жүрүр

/461./ Үнсэн эмийг ямар хүчин зүйлүүдийг анхаарч найруулдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу.
1. Шингэх хурдац

2. Эмт бодисыг өвчилсөн оронд нь жигд тархаах
3. Эмийн амт
4. Эмийн
5. Шингээлтийн амт

/462./ Уламжлалт монгол эмийн номхотголын онолыг орчин үеийн шинжлэх ухааны онолоор баяжуулж монгол эмийн номхотгох арга болон мэргэжлийг дээшлүүлж эмт бодисын чанарыг нэмэгдүүлж эмчилгээн дээрх үйлдлийг нь нэн сайн бадруулах болно. Зөв хариултыг сонгоно уу.

1. Шатаах зорилго
2. Судлах арга
3. Номхотгох зорилго
4. Судлах зорилго
5. Дэвтээх зорилго

/463./ Уламжлалт тан эмийг чанах ба дэвтээх рашаан дэвтээлэг хийхэд ус нэмэх хэмжээг чухалчилдаг. Ус нэмэх хэмжээг сонго.

1. 3-5 гр-д 250- 300 мл
2. 3-5 гр-д 200- 250 мл
3. 90 гр-д 300 мл
4. 1,5- 3 гр- д 200- 300 мл
5. 1,5- 3 гр-д 250- 300 мл

/464./ Тан эм бол ус, сүү, шөл мэтийн шингэнд эм найрлагаа чанах буюу дэвтээгээд шаарыг нь үлдээж, сүмсийг нь авах аргаар найруулсан шингэн биет найрлагын хэлбэр мөн. Учир нь тан эмийг нарийн нунтаглан сайтар хольж нийлүүлдэг тул эмийн хүч нь жигд байж дотуур гадуур алинд ч хэрэглэж болдог

/465./ Зуурмал эмийг хэрэглэхдээ өглөө эрт өлөн дээр нь уулгадаг яагаад гэвэл судлын сүв нээгдэж байгаа болохоор эмийн чадалын хүчийг бадруулахад нэн сайн байдаг

/466./ Альдостеронд эсрэг нөлөөлж шээлгэх үйлдэлтэй эмийг ол.

A. Фуросемид
B. Спиронолактон
C. Гипотаизид
D. Ацетазоламид
E. Манитол

/467./ Дараах бэлдмэлүүдийн аль нь эм бэлгийн даавaрын бэлдмэлүүд вэ?

A. Тироидин
B. Тиамазол
C. Преднизолон
D. Прогестерон
E. Буформин

/468./ Гистамины Н2 - рецепторт хориг үүсгэдэг эмийг нэрлэнэ үү?

A. Дифенгидрамин
B. Прометазин
C. Хлоропирамин
D. Клемастин
E. Ранитидин

/469./ Зүрхний гликозидын бүрэн зөв тодорхойлолтыг сонгол ол.

A. Зүрхний булчингийн агшилтыг хүчтэй болгодог эмийн зүйл.
B. Ургамлын гаралтай азот агуулаагүй органик нэгдэл
C. Гликон, агликон 2 хэсгээс тогтсон ургамлын гаралтай органик нэгдэл.
D. Ургамлын гаралтай гликон агликон 2 хэсгээс тогтсон., зүрхний булчинд сонгомол нөлөө үзүүлдэг азот агуулаагүй органик нэгдэл.
E. Ургамлын гаралтай гликон агликон 2 хэсгээс тогтсон зүрхэнд сонгомол нөлөө үзүүлдэг органик нэгдэл

/470./ Циклооксигеназа ямар үүрэгтэй вэ?

A. Фосфолипидээс цагирагт эндопероксид үүсгэнэ
B. Фосфолипидээс арахидоны хүчил үүсгэнэ
C. Цагирагт эндопероксидоос арахидоны хүчил үүсгэнэ
D. Цагирагт эндопероксидоос простогландин үүсгэнэ
E. Арахидоны хүчлээс цагирагт эхдопероксид үүсгэнэ

/471./ Дараах бэлдмэлүүдийн аль нь харшлын эсрэг үйлдэлтэй вэ?

A. Эстрадиол
B. Кальцитонин
C. Инсулин
D. Метилтестостерон
E. Кеналог

/472./ Судсанд тарих хүчтэй биш үйлдэлтэй эмийг 1 минутанд хэдэн миллилитр орохоор тооцох вэ?
A. 0.5- 1 мл
B. 1- 2 мл
C. 2-4 мл
D. 3- 4 мл
E. 4- 5 мл

/473./ Дараах мэдээллээс аль нь дихлортиазидын үйлдэлтэй тохирохыг олно уу?
A. Цусанд кали, магни, кальци багасаж, урат ихсэнэ.
B. Шээсэнд натри, хлор, кали, магни ихсэж, кальци ихэснэ.
C. Цусанд кали, магни багасаж, кальци, глюкоз ихсэж шээлгэх үйлдэл үзүүлнэ.
D. Шээсэнд натри, хлори, кали, магни, кальци, урат багасна.
E. Цусанд кали ихсэх, натри, хлор шээсэнд ихсэнэ.

/474./ Дараах дотоод шүүрлийн булчирхайнуудын аль нь стеройд бүтэцтэй даавар ялгаруулдаг вэ?
A. Сэрээ булчирхай
B. Бэлгийн булчирхай
C. Бамбай булчирхай
D. Нойр булчирхай
E. Бамбайн ойролцоох булчирхай

/475./ Ямар эмийн бэлдмэл кальцийн сувагт хориг үүсгэдэг вэ?
A. Прокаинамид
B. Хинидин сульфат
C. Дигоксин
D. Верапамил
E. Панангин

/476./ Бензил пенициллиний натрийн давсыг менингитийн үед нугасны шингэнд тарина Яагаад гэвэл цус тархины хоригийг муу нэвтэрнэ. A

/477./ Ацетилсалицилын хүчлийг цусны бүлэгнэлтийг идэвхжүүлэх зорилгоор хэрэглэнэ. Яагаад гэвэл тромбоцитын агрегацийг багасгана.

/478./ Формалиныг ариутгалд хэрэглэнэ. Яагаад гэвэл эд эсийг нягтруулж хөлс ялгаралтыг багасгана

/479./ Сульфаниламидын эмчилгээг өвчний шинж тэмдэг арилнаас хойш 2-3 хоног үргэлжлүүлнэ. Яагаад гэвэл цус төлжилтөд эсрэг нөлөөлнө.

/480./ Рибофлавиныг арьсны өвчний үед хэрэглэнэ. Яагаад гэвэл рибофлавин дутагдлын үед нүдний салст үрэвсэнэ.

/481./ Прозериныг холын харалган болгон. Яагад гэвэл прозерин нүдний цацраг булчинд ирэх парасимпатикийн сэрлийг идэвхжүүлдэг.

/482./ Пенициллинд тэсвэртэй микробоор үүсгэгдсэн өвчинд пенициллиний эмчилгээ үр нөлөө үзүүлэхгүй. Яагаад гэвэл уг өвчин үүсгэгч нь пенициллинназа фермент ялгаруулж пенициллиныг задлана.

/483./ Цефалоспорины бүлгийн эм микробын эсрэг үйлдлийн хүрээгээр пенициллиний бүлэгтэй ойролцоо. Яагаад гэвэл микробын эсийн бүрхүүлийн нийлэгжилтийг саатуулна.

/484./ Фурацилиныг ууж хэрэглэхгүй. Яагаад гэвэл антисептик.

/485./ Сульфаниламидыг сүрьеэ өвчнийг эмчлэхэд хэрэглэнэ. Яагаад гэвэл грам / + / / - / микробт нөлөөлнө.

/486./ Эмийг ямар аргаар хэрэглэхэд системийн өмнөх элиминаци хамгийн их байх вэ?

A. Венийн судсаар тарих
B. Хэлэн дор тавих
C. Булчинд тарих
D. Уух
E. Шулуун гэдсээр хэрэглэх

/487./ Ямар өвчний үед пропранололыг хэрэглэж болохгүй вэ?
A. Элэгний циррозтой өвчтөнд
B. Бөөрний архаг дутагдалтай өвчтөнд
C. Гуурсан хоолойн багтраа
D. Чихрийн шижин
E. Ходоод гэдэсний шархлаатай бол

/488./ Аминофиллины үйлдлийн үргэлжлэх хугацаа хэдэн цаг байдаг вэ?
A. 1-2 цаг
B. 2-3 цаг
C. 3-4 цаг
D. 6-8 цаг
E. 10-12 цаг

/489./ Дараах эмүүдээс алийг нь хэрэглэвэл паркинсоны хам шинж үүсэх вэ?
A. Диазепам
B. Леводопа
C. Фенобарбитал
D. Галоперидол
E. Аминофилин

/490./ Пропранололтой шууд антагонист үйлдэлтэй эмийг нэрлэ.
A. Гидрохлортиазид
B. Резерпин
C. Фуросемид
D. Изодреналин
E. Метилдопа

/491./ Богино үйлдэлтэй бетта-2-адреномиметикийг олно уу?
A. Сальбутамол
B. Аминофиллин
C. Ипратропиум бромид
D. Орципреналины сульфат
E. Сальметерол

/492./ Бага насны хүүхдэд тосонд уусамхай /липофиль/ эмүүдийн тархалтын эзлэхүүн /Vd/ хэрхэн өөрчлөгддөг вэ?
A. Багасна
B. Багасах буюу өөрчлөгдөхгүй
C. өөрчлөгдөхгүй
D. өөрчлөгдөхгүй буюу ихэснэ
E. Ихэснэ

/493./ Пропранололыг дараах эмүүдийн алинтай нь хамт хэрэглэж болохгүй вэ?
A. Верапамил
B. Гидрохлортиазид
C. Нифедипин
D. Каптоприл
E. Нитросорбид

/494./ Артерийн даралтын зохицуулгад РАС-ийг саатуулах механизмаар нөлөөлж артерийн даралт бууруулдаг эмийг нэрлэнэ үү?
A. Клонидин
B. Каптоприл
C. Миноксидил
D. Гуанетидин
E. Гидрохлортиазид

/495./ Антибиотик хэрэглэсний улмаас хүүхдийн ясжилт өөрчлөгдөн шүдний өнгө нь шарлажээ. Дараах антибиотикуудаас алийг нь хэрэглэж байсан байж болох вэ
A. Ампициллин
B. Гентамицин
C. Цефоперазон
D. Эритромицин

E. Тетрациклин

/496./ Дараах эмийн хослолуудаас ходоодны шархлааны эмчилгээнд хэрэглэдэг “сонгодог гурвал”-ыг олно уу?

A. Циметидин Амоксациллин Коллоид висмут
B. Ранитидин Амоксациллин Коллоид висмут
C. Метронидазол Амоксациллин Коллоид висмут
D. Алмагель Амоксациллин Коллоид висмут
E. Циметидин Метронидазол Коллоид висмут

/497./ Нифедипины биохүрэхүй /F/ бага байдгийн шалтгааныг ол.

A. Элгэнд системийн өмнөх элиминаци-д ордог
B. Шимэгдэлт муутай
C. Цусны плазмын уурагтай холбогддог
D. Ходоод гэдэсний замд идэвхгүйждэг
E. Биеэс хурдан ялгардаг

/498./ Теофиллины цусны плазм дахь эмчилгээний дундаж тун:

A. 10-20 мкг/мл
B. 25-30 мкг/мл
C. 30-35 мкг/мл
D. 35-40 мкг/мл
E. 5-10 мкг/мл

/499./ 65 кг жинтэй өвчтөний нойргүйдлийн эмчилгээнд фенобарбиталийг хэрэглэх болов. Түүний барих тунг тооцон олоод хэрэглэх дэглэмийг тогтооно уу?

A. 910 мг-аар өдөрт нэг удаа
B. 130 мг-аар өдөрт 2 удаа
C. 91 мг-аар өдөрт 2 удаа
D. 130 мг-аар өдөрт нэг удаа
E. 260 мг-аар өдөрт 1 удаа

/500./ Уртасгасан үйлдэлтэй үрэвслийн эсрэг нөлөөт эмийг нэрлэнэ үү?

A. Аспирин
B. Анальгин
C. Пироксикам
D. Индометацин
E. Ортофен

Сорилын зөв хариулт

1-E, 2-D, 3-B, 4-A, 5-C, 6-B, 7-D, 8-C, 9-E, 10-C, 11-C, 12-D, 13-E, 14-A, 15-A, 16-E, 17-C, 18-A, 19-C, 20-A, 21-C, 22-A, 23-A, 24-C, 25-D, 26-B, 27-A, 28-D, 29-C, 30-C, 31-A, 32-B, 33-A, 34-E, 35-C, 36-D, 37-B, 38-B, 39-C, 40-C, 41-D, 42-C, 43-C, 44-D, 45-A, 46-A, 47-B, 48-E, 49-C, 50-B, 51-B, 52-A, 53-D, 54-A, 55-C, 56-A, 57-A, 58-A, 59-A, 60-E, 61-B, 62-E, 63-B, 64-A, 65-B, 66-D, 67-B, 68-C, 69-C, 70-E, 71-A, 72-C, 73-E, 74-A, 75-A, 76-A, 77-A, 78-D, 79-A, 80-E, 81-C, 82-C, 83-B, 84-E, 85-B, 86-D, 87-E, 88-C, 89-C, 90-C, 91-A, 92-C, 93-C, 94-A, 95-B, 96-C, 97-C, 98-B, 99-E, 100-E, 101-D, 102-B, 103-B, 104-C, 105-C, 106-D, 107-C, 108-A, 109-A, 110-E, 111-D, 112-E, 113-E, 114-C, 115-E, 116-A, 117-A, 118-D, 119-B, 120-A, 121-C, 122-D, 123-A, 124-C, 125-C, 126-A, 127-E, 128-C, 129-A, 130-E, 131-C, 132-A, 133-A, 134-E, 135-B, 136-E, 137-E, 138-E, 139-B, 140-C, 141-C, 142-C, 143-E, 144-E, 145-A, 146-B, 147-C, 148-C, 149-A, 150-A, 151-E, 152-B, 153-C, 154-A, 155-A, 156-A, 157-A, 158-E, 159-E, 160-B, 161-E, 162-A, 163-A, 164-E, 165-A, 166-B, 167-B, 168-A, 169-A, 170-A, 171-C, 172-C, 173-D, 174-D, 175-B, 176-D, 177-D, 178-A, 179-D, 180-D, 181-C, 182-C, 183-A, 184-A, 185-A, 186-B, 187-D, 188-C, 189-C, 190-C, 191-C, 192-C, 193-B, 194-A, 195-D, 196-A, 197-A, 198-A, 199-A, 200-A, 201-A, 202-E, 203-B, 204-A, 205-C, 206-C, 207-A, 208-C, 209-A, 210-A, 211-E, 212-E, 213-C, 214-A, 215-C, 216-E, 217-A, 218-C, 219-A, 220-C, 221-D, 222-C, 223-A, 224-B, 225-A, 226-B, 227-A, 228-E, 229-D, 230-D, 231-C, 232-A, 233-E, 234-B, 235-A, 236-D, 237-A, 238-E, 239-A, 240-E, 241-C, 242-A, 243-D, 244-A, 245-C, 246-E, 247-C, 248-A, 249-E, 250-A, 251-A, 252-D, 253-B, 254-B, 255-D, 256-B, 257-A, 258-C, 259-C, 260-E, 261-A, 262-A, 263-D, 264-A, 265-C, 266-E, 267-D, 268-D, 269-A, 270-A, 271-E, 272-B, 273-C, 274-C, 275-A, 276-D, 277-D, 278-E, 279-B, 280-E, 281-C, 282-E, 283-A, 284-C, 285-A, 286-B, 287-C, 288-D, 289-C, 290-E, 291-A, 292-A, 293-A, 294-B, 295-C, 296-B, 297-B, 298-B, 299-A, 300-A, 301-E, 302-E, 303-E, 304-A, 305-A, 306-B, 307-D, 308-C, 309-E, 310-B, 311-A, 312-B, 313-B, 314-B, 315-C, 316-C, 317-D, 318-A, 319-C, 320-B, 321-B, 322-C, 323-D, 324-B, 325-C, 326-C, 327-B, 328-B, 329-B, 330-B, 331-A, 332-C, 333-C, 334-D, 335-E, 336-C, 337-E, 338-B, 339-B, 340-C, 341-B, 342-C, 343-C, 344-D, 345-B, 346-C, 347-B, 348-C, 349-D, 350-A, 351-C, 352-D, 353-C, 354-B,

355-D, 356-D, 357-C, 358-C, 359-C, 360-C, 361-E, 362-C, 363-D, 364-D, 365-D, 366-A, 367-A, 368-C, 369-A, 370-E, 371-A, 372-D, 373-A, 374-C, 375-C, 376-C, 377-D, 378-E, 379-C, 380-B, 381-B, 382-C, 383-C, 384-C, 385-B, 386-A, 387-E, 388-E, 389-A, 390-C, 391-C, 392-B, 393-B, 394-B, 395-C, 396-E, 397-C, 398-E, 399-B, 400-C, 401-D, 402-B, 403-D, 404-C, 405-E, 406-B, 407-C, 408-B, 409-C, 410-C, 411-D, 412-A, 413-B, 414-B, 415-D, 416-E, 417-A, 418-A, 419-C, 420-A, 421-E, 422-B, 423-E, 424-A, 425-A, 426-A, 427-E, 428-A, 429-C, 430-C, 431-D, 432-C, 433-A, 434-B, 435-C, 436-E, 437-B, 438-D, 439-E, 440-B, 441-A, 442-B, 443-D, 444-B, 445-C, 446-E, 447-B, 448-B, 449-A, 450-C, 451-C, 452-D, 453-D, 454-D, 455-D, 456-C, 457-C, 458-A, 459-A, 460-C, 461-E, 462-D, 463-A, 464-B, 465-A, 466-B, 467-D, 468-E, 469-D, 470-E, 471-E, 472-C, 473-C, 474-B, 475-D, 476-D, 477-D, 478-B, 479-B, 480-B, 481-C, 482-A, 483-D, 484-D, 485-D, 486-D, 487-C, 488-D, 489-D, 490-D, 491-A, 492-A, 493-A, 494-B, 495-E, 496-C, 497-A, 498-E, 499-D, 500-C,